

Р.Энхбат, Г.Ариунцэцэг, А.Оюунтунгалаг, Ц.Одонтуяа,  
Б.Дэлгэрмаа, Ж.Хишигжаргал, Д.Баттогтох, Ч.Баттулга,  
Л.Орхонтуул, Д.Одонтуяа, О.Наранчимэг, Ш.Пунсалдулам,  
Д.Долгорцэцэг, Б.Гансайхан, Т.Нансалмаа, Б.Алтанмандах,  
Ц.Амарсанаа, Б.Батцэцэг, Ж.Саранчимэг

# МОНГОЛ ЁС, ХҮМҮҮЖИЛ

## II

Ерөнхий боловсролын сургуулийн  
2 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

ННА я7  
ДАА 371.3  
М-692

Монгол ёс, хүмүүжил II: Ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар ангийн сурах бичиг. /Энхбат Р., ба бусад; Ред. Чоймаа Ш. -УБ. 2019. - 80х.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-9919-503-18-5

## Хүүхдүүд ээ!

“Монгол ёс, хүмүүжил” хичээлээ судлахаар шамдаж буй та нартаа баярлалаа.

Энэхүү сурах бичиг та бүхэнд сайхан сэтгэл, саруул ухаан, эелдэг зантай, ёс уламжлалаа мэдэж сахидаг, бусдад ачлалтай нэгэн болоход тань туслах хөтөч байх болно.



Номын “Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье” бүлэг монголчууд улиралд тохируулан хэрхэн мэндэлдэг вэ, хүн яагаад бодож сэтгэх, хийж бүтээх чадвартай вэ, яагаад эрдэм ном сурах ёстой вэ зэрэг асуултад хариулна. Мөн чи үг ямар хүчтэй болох, үг хэлээрээ эелдэг зөөлөн, эвтэй байхын чухлыг энэ бүлгээс мэдэх болно.

“Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс” бүлэг хүмүүс яагаад хамтдаа амьдардаг юм бол, чиний төлөө хэн санаа тавьдаг, хэн чиний ачтан бэ, бусдыг хэрхэн хүндлэх ёстой вэ зэрэг асуултад чинь хариулна.



Харин “Уламжлалт аж төрөх ёс, зан үйл” бүлгээс чи цагаан сарын баяр, битүүний тухай олон зүйлийг мэдэж авна. Тухайлбал чи битүүнийг яагаад битүүн, цагаан сарыг яагаад цагаан сар гэдгийн учрыг мэдэх үү? Энэхүү баяраар золгохдоо хэлдэг ерөөлийн үгс ямар утгатай болох, хэрхэн зөв золгох вэ? Цагаан сарын бэлэг ямар утгатай вэ? Мөн чи таван хошуу малыг нас насаар нь юу гэж нэрлэдгийг мэдэх үү?

Энэ бүхнийг мэдэхийг хүсэж байвал номоо шимтэн судлаарай!

## ТАНИХ ТЭМДЭГ



Анхааралтай  
сонсоорой



Анхааралтай  
ажиглаарай



Ярилцаарай



Бичээрэй



Уншаарай



Яриарай



Тэмдэглээрэй



Харгалзуулаарай



Зураарай



Тоглоорой



Хосоор  
ажиллаарай



Багаар  
ажиллаарай



Гэрийн  
даалгавар



Санамж

## ГАРЧИГ

### I БҮЛЭГ: Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье

1. Алтан намар . . . . .	8
2. Эрдэнэт хүн . . . . .	11
3. Хүн болон адгуусан амьтны ялгаа . . . . .	13
4. Хүн юу хийх чадвартай вэ? . . . . .	14
5. Ховор заяа . . . . .	15
6. Эрдэмд шамдахуй . . . . .	16
7. Эрхмийн дээд эрдэм мэдлэг . . . . .	19
8. Цаг бол алт . . . . .	20
Б. Сайн үйлийг сахиж, муу үйлийг тэвчих ёс . . . . .	24
9. Буян, нүгэл . . . . .	24
10. Үг шидтэй болов уу? . . . . .	26
11. Хэлээр үйлдэх сайн, муу үйл . . . . .	28
12. Үг бол бүтээх, эвдэх чадалтай . . . . .	29
13. Худалд үнэн үгүй . . . . .	30
14. Ховловол гутна . . . . .	33
15. Ширүүн үг сэтгэл өвтгөнө . . . . .	35
16. Дэмий чалчих . . . . .	37

### II БҮЛЭГ: Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс


1. Хүн хүндээ түшиг . . . . .	40
2. Эхийн элбэрэл . . . . .	42
3. Ээжийнхээ үгэнд ороорой . . . . .	44
4. Уул шиг түшигтэй ачтан . . . . .	45
5. Аавын аяга . . . . .	46
6. Эцэг эхийн ач . . . . .	47
7. Эвсэг гэр бүл . . . . .	48
8. Гэр бүлээ хэрхэн хүндэлж, баярлуулах вэ? . . . . .	49
9. Хүндлэх сайхан . . . . .	50
10. Нэг ангийнхан . . . . .	51
11. Энгүй их ачтан . . . . .	54
12. Талархал . . . . .	56
13. Уучлал . . . . .	60

### III БҮЛЭГ: Уламжлалт аж төрөх ёс, зан үйл

1. Борхүүгийн дах . . . . .	61
2. Битүүн . . . . .	63
3. Ерөөлөөр болог . . . . .	65
4. Цагаан сарын мэндчилгээ . . . . .	66
5. Цагаан сарын цээр . . . . .	69
6. Гарын бэлэг . . . . .	70
7. Таван хошуу малын нас . . . . .	72
8. Таван хошуу малаа насаар нь ялган нэрлэж суръя . . . . .	75
9. Үхэр үү? Сарлаг уу? . . . . .	77

СУРГУУЛЬДАА ЯАРНА  
СУРАХДАА ШАМДАНА





## АМРЫГ АЙЛТГАЖ, МЭНДИЙГ МЭДЭХ ЁС

## 1. АЛТАН НАМАР



Намрын улиралд хэрхэн мэндлэх вэ?

- А Сайн байна уу, та?
- Б Та тарган сайхан намаржиж байна уу?
- В Та тавтай сайхан намаржиж байна уу?



Эрдэнэ аавтайгаа хөдөө байдаг өвөөгийнхөө очжээ. Аав нь “Сайхан намаржиж байна уу? Мал сүрэг тарган уу?” хэмээн мэндэллээ. Өвөө нь “Сайхан намаржиж байна. Та бүхэн сайхан намаржиж байна уу? Энэ жил сайхан намар болж, мал сүрэг тарга тэвээрэг сайн авлаа” гэж хариулав.

Эрдэнэ “Аав аа, та ирэх бүрдээ өөр өөрөөр мэндлэх юм аа” гэв. Аав нь инээн “Монголчууд жилийн дөрвөн улиралдаа тохируулан мэнд мэддэг ёстой. Тиймээс аав нь намрын улирлын мэндийг асуусан юм” хэмээн хариуллаа.

“Тэгвэл өвөл, хавар, зун яаж мэндэлдэг юм бэ?” гэж Эрдэнэ ааваасаа сониучирхан асуув.

Өвөл бол “Тарган тавтай өвөлжиж байна уу? эсвэл “Өвөлдөө өнтэй сайхан орж байна уу?” хэмээн мэндэлдэг. Хавар мал төллөдөг учраас “Сайхан хаваржиж байна уу? Төл мэнд, сүрэг өсөж байна уу?” гэнэ. Харин зун айлчлан ирвэл өвөөтэйгөө “Бие амар, мал сүрэг мэнд, тарган сайхан зусаж байна уу?” гэж мэндлээрэй хэмээгээд хүүгийнхээ толгойг илэв.



Монголчууд улирал тус бүрд хэрхэн мэндэлдэг вэ? Дээрх эхээс мэндийн тохирох өгүүлбэрийг олж бичээрэй.








Дараах мэндийн үгс ямар улиралд тохирох вэ? Яагаад ингэж мэндэлдэг талаар ярилцаж, өвөө эмээгээсээ мэндийн үгийг нэмж сураарай.

Мал тарга тэвээрэг сайн авч байна уу?

А

1



Мал сүрэг тарга сайн авав уу?

Б

2



Төл мэнд, сүрэг өсөж байна уу?

В


3



Мал сүрэг мэнд, өнтэй сайхан өвөлжиж байна уу?

Г

4



- Жижиг цаасан дээр дөрвөн улирлыг тус тусад нь зураарай.
- Найзтайгаа улирлын зургаа ээлж дараалан сугалж, тухайн улиралд тохирох мэндийн үгээр амар мэндийг асууж, хариу мэнд мэдэж тоглоорой.



Намрын улиралд болдог үйл явдалд тохируулан мэндийн үгс зохиогоорой.

Намаржаандаа буудаг.	Айргаа исгэж, өвөлдөө нөөцлөн бэлтгэдэг.
Хадлан, бордоогоо авдаг.	Хүн малынхаа хүнс тэжээлийг бэлддэг.
Ургацаа хураадаг.	Мал сүрэг нь тарга хүчээ сайн авч гүйцдэг.
Өвөлжөөнийхөө хашаа хороог засаж сэлбэдэг.	Өвөлдөө бэлтгэн эсгийгээ хийж, гэрийнхээ бүрээсийг оёдог.
Унагаа тамгалдаг.	Цагаан идээгээ бэлтгэн, өвөлдөө нөөцөлдөг.



Намраас бусад улиралд гүйцэтгэдэг гол ажлуудыг тоочин ярилцаад, доор өгөгдсөн мэндийн үгсийг улирлаар нь ангилаарай.

- Ус өвс элбэг дэлбэг, тарган сайхан өвөлжиж байна уу?
- Өвөлжөө бууц тавтай, чоно нохой тайван уу?
- Малын тарга хүч тогтож, тавтай сайхан намаржиж байна уу?
- Өвс хадлан их авч, өвлийн бэлтгэл сайн уу?
- Тарган тавтай хаваржиж байна уу?
- Зуншлага сайхан болж байна уу?
- Ногоо цагаа элбэг дэлбэг үү?
- Газрын гарц, малын тарга хүч сайн уу?
- Хур бороо элбэг, мал сүрэг таргалж байна уу?

Өвлийн улиралд тохирох мэндийн үгс	Хаврын улиралд тохирох мэндийн үгс	Зуны улиралд тохирох мэндийн үгс	Намрын улиралд тохирох мэндийн үгс



## 2. ЭРДЭНЭТ ХҮН




Багштайгаа ээлжилж уншаарай.

### Хүн байхын сайхныг ухаарсан нь

Гэрээ цэвэрлэх дургүй ч гэдсээ дүүргэх дуртай, оройтож босох дуртай ч ороо хураах дургүй, оймсоо ч угаадаггүй нэгэн жаал хүү байжээ. Өнөөх хүү нэг удаа нохойгоо хараад ихэд атаархав. “Хэрэв би нохой байсан бол амар байхгүй юу. Хог шүүрдэж, аяга угаахгүй. Эзнийхээ өгсөн хоолыг идчихээд өдөржин хэвтэнэ” гэж боджээ. Тэгтэл бодлыг нь мэдсэн юм шиг гэнэт нэгэн шидтэн гарч ирээд түүнийг хүслээ хэлнэ үү хэмээн эелдгээр асуулаа. Хүү бодох зүйлгүйгээр: -“Би нохой болмоор байна” гэв. Шидтэн ч түүнийг хоточ нохой болгож орхив. Өвлийн хүйтэнд гадаа хонож, өлөн саарал чоно дайрахад хонь малаа хамгаалав. Өлсөж бас даарч, нүд цавчилгүй нэг шөнийг арайхийн өнгөрөөлөө. Тэгээд хүү шидтэнээс: -Би нохой байхаа больё. Намайг тасалгааны цэцэг болгоод өгөөч гэж гуйлаа. Хүү хүссэн ёсоороо цэцэг болчихоод зөвхөн ус уугаад, ямар ч хөдөлгөөнгүй өдрийг өнгөрөөв. Цэцэг байх нь тийм ч амар биш байлаа. Жижиг хорхойнууд бие дээгүүр нь гүйлдэж, тэсэхийн аргагүй гижиг хүргэнэ. Хурц нар шарж, гэрийн хүмүүс услахаа мартаж, ангаж цангана. Тоос шороонд дарагдан тогтсон нэг газраа зогсоно гэдэг жаргал биш болохыг мэдрэв. Ингээд шидтэнээс: -“Намайг буцаагаад хүн болгож өгөөч. Хүн байх л хамгийн сайхан юм байна” хэмээн өрөвдөлтэйгөөр гуйлаа. Шидтэн хүүг буцаан хүн болгов. Хүү бөөн баяр болж, тэр өдрөөс хойш хойргошин залхуурахыг хол хаяж, ажилсаг авхаалжтай хүү болж, эрдэм номд шамдан, ээж аавыгаа баярлуулах болжээ.



Зургийг зөв дараалалд оруулаарай.





Чиний бодлоор ямар амьтан байсан нь илүү дээр вэ? Яагаад? Амьтан бүрийн сул болон давуу талыг харьцуулан ярилцаарай.



Өөрийн бодлыг бичье.

Асуулт	Чиний бодлоор	Хүн юугаараа илүү вэ?
Хамгийн хурдан амьтан юу вэ?		Хүн машин бүтээж, үчимбэрээс хурдан давхиж чадна.
Хамгийн хүчтэй амьтан юу вэ?		
Хамгийн өндөр амьтан юу вэ?		

► Үчимбэр хуурай газрын хамгийн хурдан амьтан бөгөөд богино зайд 120 км/цаг хүртэл хурдалдаг.



Хүн амьтнаас зарим чадвараар дутуу. Гэхдээ хүн сэтгэн бодох чадвартай учир хүссэн бүхнээ хийж чадна. Хайрлан энэрэх сэтгэлтэй тул бусдад тусалж, сайн үйлсийг бүтээх төгс боломжтой. Иймд хүн болж төрсөн бид азтай.

### 3. ХҮН БОЛОН АДГУУСАН АМЬТНЫ ЯЛГАА



Ямар амьтан хүнтэй хамгийн төстэй бэ?



Бичний гар



Хүний гар



Амьтдын дотроос хүн дүрст бич нь хүнтэй хамгийн төстэй. Бич нь хүний өвөг дээдэс мөн эсэх одоог хүртэл маргаантай. Гэвч хүний өвөг дээдэс бичнээс олон талаар илүү байв. Жишээ нь, Бич дөрвөн хөл дээрээ явдаг бол хүн хоёр хөл дээрээ босоогоороо явдаг. Эрхий хуруу нь бусад хурууныхаа өндөгтэй чөлөөтэй нийлдэг учир хүн ямарваа зүйлийг сайтар барьж чаддаг, бас илүү том тархитай байжээ.

Эрт дээр үед хүмүүс салхи, цас борооноос хоргодох, махчин амьтдаас өөрсдийгөө хамгаалахын тулд агуйд олуулаа амьдардаг байв. Чулуугаар зэвсэг хийж, гал гаргаж, хоорондоо ярилцаж сурсан нь хүний хамгийн чухал амжилтууд байлаа.

Улмаар хэл яриа хөгжин, хүмүүс хоорондоо илүү сайн ойлголцдог болжээ. Хүмүүс ийнхүү тасралтгүй суралцаж, хөдөлмөрлөж, оюун ухаан нь хөгжсөөр өнөөдрийн бидэнд байгаа бүхнийг бүтээжээ.



Хүн яагаад бодож сэтгэж, бүтээж чаддаг вэ? Үүний хариултыг эхээс олж, өнгөөр тодруулан ялгаарай.



Хүн төрөлхтөн юуны хүчээр өнөөгийн түвшинд хүрсэн бэ?



Бидний гар хийж бүтээдэг.

- Эрхий хурууныхаа өндгийг бусад хурууныхаа өндгүүдтэй ээлжлэн нийлүүлж үзээрэй. Долоовор, дунд, ядам, чигчий хурууны өндгүүд нь эрхий хурууныхаа өндөгтэй нийлж байна уу?
- Улам хурднаар нэгээс дөрөв хүртэл тоолж, хуруунуудаа нэг нэгээр нь эрхий хурууныхаа өндөгтэй гурван удаа нийлүүлээрэй.

Хүн ухаанаа түшнэ  
Мод хальсаа түшнэ

Хүний тамир сэтгэлдээ  
Морины тамир шандсандаа

## 4. ХҮН ЮУ ХИЙХ ЧАДВАРТАЙ ВЭ?



Чиний бодлоор, хүн төрөлхтний бүтээсэн хамгийн чухал зүйлс юу вэ? Дараах зүйлсийн аль нь илүү чухал вэ?



Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн өнөөг хүртэл маш их зүйлийг бүтээжээ. Агуйд амьдарч байсан хүн төрөлхтөн өдгөө өндөр байшин сүндэрлэсэн, автомашин сүлжилдсэн хотуудад амьдарч байна. Дэлхийн хаанаас ч хоорондоо утсаар ярьж, онгоц хөлөглөн хүссэн газартаа хүрэх болов. Сансрын хөлгөөр аялж, шинжлэх ухааныг хөгжүүлсээр байна. Өвдсэн хүнийг эмчлэн эдгээх олон төрлийн эм, тариа, эмнэлгийн төхөөрөмжийг бүтээжээ. Энэ мэт хүн төрөлхтний хийж бүтээж бий болгосныг тоочих аргагүй.



Энэ бүх гайхамшгийг бий болгоход нөлөөлсөн хамгийн чухал зүйлс бол хүний оюун ухаан, сэтгэл, хэл яриа, бичиг үсэг, ном юм. Нэгэн ухаантан "Хүн төрөлхтний бүтээсэн зүйлсийн дотор ном шиг гайхамшигтай зүйл үгүй" хэмээн хэлсэн байдаг.

Хүн төрөлхтөн сайн сайхныг бүтээгээд зогсохгүй муу муухайг ч бий болгож амжжээ. Буу зэвсэг, тэсрэх бөмбөг, цөмийн зэвсгийг үйлдэв. Дайны уршгаар олон сая хүн амиа алдсан.



Оюун ухаант хүн төрөлхтөн чухам ямар үед энэрэн хайрлаж, бүтээн босгоод, ямар үед устган сөнөөнө вэ? Хүн бусдын төлөө сайхан сэтгэлтэй бол авран хамгаалж, бүтээн босгодог. Харин шунаж, амин хувиа хичээсний

гайгаар эх дэлхийгээ сэвтүүлэн, ургамал амьтдыг устган хөнөөж байна. Тиймээс өвөг дээдэс маань "Сэтгэл хаашаа, бие тийшээ", "Сэтгэл бол биеэс эрхэм" хэмээн үр хойчдоо сургасаар иржээ. Энэ нь сайхан сэтгэл хамгаас чухал гэдгийг харуулж байгаа юм.





Хүний хийж бүтээсэн сайн, муу гурван зүйлийг эхээс олж бичээрэй.

	Хүний бүтээсэн сайн зүйлс	Хүний хийсэн муу зүйлс
1		
2		
3		




- Хүн ямар үед сайн, ямар үед муу зүйл хийдэг вэ?
- Хүн шиг асар ихийг хийж бүтээх, бас устгаж хөнөөх чадвартай амьтан бий юү?

## 5. ХОВОР ЗАЯА



Манай дэлхий дээр жигүүртэн шувууд, адгуусан амьтад, загас жараахай, хорхой шавж зэрэг маш олон зүйлийн амьтан байдаг.

Шоргоолжны ганц үүрэнд гэхэд дэлхийн бүх хүнтэй адил тооны (7 000 000 000 - долоон тэрбум) шоргоолж байдаг гэвэл чи итгэх үү? Тэгвэл хүн болж төрөх нь хэчнээн ховор хувь заяа болохыг дараах эхээс олж мэдээрэй.



### Эмээгийн хариулт

Номин охин 7 настай. Нэгэн удаа дүүтэйгээ нохой болон тоглоод, газарт дөрвөн хөллөөд хуцаж гарчээ. Гэтэл эмээ нь:

- Нүгэл гэм, хүн байж амьтан болоод муу ёртой юм гэж ундууцжээ. Тэгэхэд нь Номин:

- Тэгвэл би яагаад хүн болж төрсөн юм бэ гэж асуув. Эмээ нь:

- Ай, хүн болж төрөх чинь маш ховор хувь заяа шүү дээ. Зүйрлэвэл нэг зүүг дээш харуулж тогтоогоод, атга шар будаа дээрээс нь аажуухан асгаад байвал хэзээ нэгэн цагт зүүний үзүүрт нэг будаа тогтох төдий болно. Хүн болж төрнө гэдэг үүнтэй адил ховор тохиолдол юм шүү гээд эмээ нь охиныхоо духыг үнэрлэн үнсжээ.



Асуултын дагуу ярилцаарай.

- Хүн болж төрөхийг Номин охины эмээ юутай зүйрлэсэн бэ?



Хүн болж төрсөн учир бид юу хийх ёстой вэ?



Дараах зүйр үгсээс хоёрыг сонгон, утгыг тайлбарлаж бичээрэй.

- Биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал
- Хүний хүчинд хүн болдог, усны хүчинд загас болдог.
- Хүн өөдөө, ус уруугаа
- Хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа.
- Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа.
- Хүнд сэтгэл байдаг, цахиурт гал байдаг.



цахиур



Хүн болон төрөх боломжийг “олдохуйяа бэрх эрдэнэт хүний бие” хэмээн өвөг дээдэс маань судар номд тэмдэглэсэн байдаг. Хүний нас харьцангуй богино. Тиймээс цаг хугацааг алдалгүй ашиглан, эрдэм номд шамдан, бие, хэл, сэтгэлээ хөгжүүлээрэй. Өөрийн эрхэм биеийг бусдад туслах, энэрэн хайрлах сайн үйлсэд зориулаарай.

## 6. ЭРДЭМД ШАМДАХУЙ



Чиний бодлоор хэн нь сайн сурах вэ?







### Савны гурван гэм

Нэгэн багш хичээлийн эхний өдөр шавиа аяга авчрахыг хүсэв. Шавь ч хэлсэн ёсоор аяга авчирлаа. Багш:

- “За хүү минь, аягаа урдаа хөмрөөд тавь” гэв. Шавь нь аягаа урдаа хөмрөн тавихад багш хөмөрсөн аяганы дээрээс данхтай цайнаасаа хийж эхэллээ.

Цай гадуур нь асгарсан ч багш өөр зүйл ярьж, цайгаа хийсээр байв. Шавь нь сандарч “Багш аа, аягаа дээш нь харуулах уу?” гэж асуув. Багш нь толгой сэгсрээд цайгаа хийсээр байлаа. Ийнхүү нэлээд асгасны эцэст “За, хүү минь хичээлийн эхний хэсэг дууслаа” хэмээв. Шавь нь юу ч ойлгосонгүй.



Багш нь үүгээр түүнд юу ойлгуулах гэсэн юм бол?



Хэсэг завсарлаад хичээлийн дараагийн үе эхлэв. Багш нь түүний урд ёроол нь цоорхой аяга тавиад бас л данхтай цайнаасаа хийлээ. Цоорхойгоор цай гоожиж эхлэв. Шавь нь гайхаж “.....” гэв. Багш өмнөхийн адил өөр зүйл ярингаа цайгаа хийсээр байв. Ингэж хэсэг асгаад багш нь “Хичээлийн дунд хэсэг дууслаа” гэжээ.



Шавь нь юу гэж хэлсэн бол? Бичээрэй.



Хичээлийн гурав дахь үе эхлэхэд багш нь бохир аяганд цай хийгээд “Цай уу, миний хүү” гэв. Шавь гайхаж “Багш аа, аяга бохир байсан. Би ууж чадахгүй нь, өршөөгөөрэй” гэжээ.

Ингээд багш нь “За, өнөөдөр би чамд гурван хичээл заалаа. Юу сурснаа ярь даа” гэв. Шавь нэлээд бодсоны эцэст хариулжээ.



Шавь хэрхэн хариулсан бэ?

- Цэгийн оронд ямар үг тохирох вэ?
- Дараа нь өгүүлбэрүүдийн зөв дарааллыг тэмдэглээрэй.

Хичээлийн эхний  
хэсгээр

Хичээлийн дунд  
хэсгээр

Хичээлийн төгсгөл  
хэсгээр

- 1 ..... хичээлээ анхаарч сонсохгүй байвал ном сурахгүй гэж заалаа.
- 2 ..... хичээлээ сонссон ч сурсан зүйлээ давтахгүй бол эрдэм ном сурахгүй гэж заалаа.
- 3 ..... багшийн заасанд итгэхгүй, эсрэг бодолтой, буруу сэтгэлээр сонсвол эрдэм ном сурахгүй болохыг заалаа.

Заасныг нь ийнхүү сайтар ойлгосон шавьдаа багш нь “Их сайн байна” гээд шинэ хичээлээ зааж эхэлсэн гэдэг.



Хичээлээ сурахгүй сурагчийг багш ямар савтай зүйрлэсэн бэ? Дараах хоёр баганыг зөв харгалзуулаарай.

Хичээлээ анхаардаггүй  
сурагч

(А)

(1)



Буруу сэтгэлээр сонсдог  
сурагч

(Б)


(2)



Хичээлээ давтдаггүй  
сурагч

(В)

(3)



Чи өөрийгөө дээрх савнуудтай зүйрлэвэл аль нь вэ? Эсвэл аль нь ч биш үү? Өөрийгөө аягаар төлөөлүүлж зураарай.



Хичээл номыг хэрхэн сонсож, сурах ёстойг дүгнэн ярилцаарай.

## 7. ЭРХМИЙН ДЭЭД ЭРДЭМ МЭДЛЭГ

Эрхэм баян эрдэм, дунд баян үр хүүхэд, адаг баян эд хөрөнгө



Эрдэм номыг хэзээнээс эхэлж сурсан нь сайн бэ? Яагаад?



Эрт цагт хааны хөвгүүн, харцын хөвгүүн хоёр сайхан нөхөрлөдөг байжээ. Харц хүн хөвгүүнээ эрдэм ном сургахад бүхнийгээ зориулжээ. Хөвгүүн ч аавынхаа итгэлийг алдсангүй, номд мэргэн болов. Харин хаан “Эрдэм ном сурахад амаргүй, хөвгүүн маань ядарч зүдэрнэ, аливаа бүхэн бэлэн байна” гээд хөвгүүндээ эрдэм ном эс сургажээ.

Хөвгүүд өсөж том болоход хааны хөвгүүн аавдаа:

- Надад эрдэм ном сургаагүй нь үнэхээр харамсалтай. Би үеийн нөхрөөсөө үлэмж доор болов гэхэд хаан аав нь:
- Тэр харцын хөвгүүн амиа тэжээхийн тулд эрдэм сурчээ. Эрдэмт ганц хөвгүүнийг хамгийг эзлэгч хаантай адилтгах хэрэг юун. Чи хаан язгууртай. Чамд эд баялаг, эрх мэдэл, шадар түшмэд гээд хүнд хэрэгтэй бүгд дуусашгүй их байна шүү гэв. Тэгэхэд хөвгүүн:
- Хаан хүн ганц өөрийн улсад л өргөгдөнө. Эрдэмтэй хүн аль ч улсад одсон тэнд хүндлэгдэнэ. Элдэв ганганыг өмсөж, эрдэнэсээр биеэ чимэвч эцэст нь элэгдэж, эвдэрч дуусна. Эрдэм мэдлэг харин биетэйгээ үүрд хамт байна. Бас тэгээд харийн хаан довтлон эзэлбэл эдгээр их эд баялаг эрх мэдлээс юу ч үлдэхгүй. Мэргэн хүний эрдмийг хэн ч булаан авч чадахгүй билээ гэхэд хаан аав нь:



- Чи үнэхээр хүсэж, эрдмийн чухлыг мэдэж байгаа бол чамд хэрэгтэй бүхнийг өгье. Одооноос хичээнгүйлэн эрдэм сурагтун гэв. Хөвгүүн:
- Тарианы үрийг хавар цацаад намар боловсрох, эрдмийг бага насанд сураад том болоход хэрэглэх ёс буй. Тийнхүү хожимдсон боловч хаан эцгийн зарлигаар болсугай хэмээжээ.

Тэр цагаас хойш хааны хөвгүүн эрдэм номыг хичээнгүйлэн сурч, төрийг номын ёсоор тэтгэн барих болжээ.




Асуултын дагуу ярилцана уу.

- Хааны хөвгүүн насны багад эрдэм сураагүйдээ яагаад харамссан бэ?
- Хааны хөвгүүн ааваасаа ухаалаг байсанд хэн нөлөөлсөн бэ?
- Дээрх эхэд юу эвдэрч, элэгдэж дуусдаг гэж өгүүлсэн бэ? Харин юу биетэйгээ хамт ямагт байдаг вэ?
- Хүнээс хэн ч булаан авч чадахгүй тэр зүйл юу вэ?
- Ямар хүн өөрийн улс төдийгүй хаа ч явсан хүндлэгдэх вэ?



Эрдэм мэдлэгтэй боловч эд баялаггүй байх, эд баялагтай боловч эрдэм мэдлэггүй байхын ялгаа юу вэ? Хариултыг олоход дээрх үлгэр чамд тусална.

Эрдэм мэдлэгтэй боловч эд баялаггүй байх	Эд баялагтай боловч эрдэм мэдлэггүй байх



## 8. ЦАГ БОЛ АЛТ



Дараах оньсогыг таагаарай.

Аав, ээж, хүү гурав  
Айлуудад зочилно  
Аав нь нэг айлд  
Ээж нь жаран айлд  
Харин хүү 360 айлд ороод гарна.



Жилд хэдэн хоног, хоногт хэдэн цаг, нэг цагт хэдэн минут, нэг минутад хэдэн хором байдгийг бодоорой.



Өглөө бүр дансанд чинь 5000 төгрөг оруулдаг банк байна гэж төсөөл дөө. Мөнгийг дураараа хэрэглэж болно. Гагцхүү тэр өдөр л өнгөрвөл хэдэн ч төгрөг үлдсэн байсан данс хоосон болно.



Тэгвэл чи яах вэ?



Магадгүй нэг ч төгрөг үлдээлгүй хэрэглэх биз. Энэ хэдий хоосон төсөөлөл мэт боловч амьдрал дээр хүн бүхэнд ийм банк бий. Тэр бол цаг хугацаа юм. Цаг хугацаа хэмээх тэр банканд мөнгө бус хором, мөч байдаг. Ашиггүй өнгөрөөсөн цаг эргэж бидэнд ирэхгүй. Өчигдөр өнгөрөн одож, маргааш оньсого таавар болон угтаж байдаг. Харин өнөөдөр бол бидэнд оногдсон эрдэнэ юм шүү.



Өчигдрийг хэрхэн өнгөрүүлснээ санаад, дэвтэртээ тэмдэглэж бичээрэй.

Өглөө: .....

Үдийн өмнө. ....

Үд: .....

Үдээс хойш: .....

Орой: .....

Үдэш: .....



Өөрийгөө дүгнэе. Би өдрийг    өнгөрүүлж байна.

Үр ашигтай

Үр ашиг дунд зэрэг

Үр ашиг багатай

## Бялзуухайн үүр



Шаазгай бусадтайгаа хамтран үнэхээр уран, салхи шуурганд хийсэж унахааргүй бат бөх үүр барьдгийг та нар мэдэх үү?



Бялзуухай үүр барина гэсэн чимээг барилгачин шаазгай сонсжээ. Шаазгай бялзуухайд нэгэн зураг төлөвлөгөө зурж өгөөд “Дүү минь, чи миний энэ зургийн дагуу баривал лав сайн үүр болно. Барихад чинь ямар нэг бэрхшээл тохиолдвол намайг эрж очоорой. Би чамд дуртайяа тусална” гэжээ. Бялзуухай тун их баярлаж “Эгч танд их баярлалаа. Би барих зүйлээ бушуухан бэлтгэж хурдан барья. Та маргааш ирж надад хэрхэн барихыг зааж өгөөч” гэжээ. Шаазгай ч зөвшөөрч тэр хоёр маргаашийн өдөр уулзахаар хэлэлцэн тохиров.

Маргааш өглөө нь шаазгай иртэл бялзуухай “Эгч ээ уучлаарай. Өчигдөр би тагтаа ахын хуримд очоод амжсангүй. Та маргааш ирж болох уу? Би сайхан бэлтгээд байя” гэв. Маргааш нь шаазгай бас л ирж гэнэ. Бялзуухай түүнийг хараад “Аяа, их муухай осол боллоо. Өчигдөр хөхөө эгчийн төрсөн өдөрт очоод бэлтгэж чадсангүй. Та маргааш ирж туслаач” гэжээ. Дараа өдөр нь шаазгай бас ирэв. Бялзуухай шаазгайг хармагц сандран “Үнэхээр муухай юм боллоо. Өчигдөр би үүр барихдаа бэлтгэж байтал шар шувуу ах ирж, хууч хөөрсөөр бас юу ч хийж чадсангүй. Та маргааш ирж болох уу?” гэжээ. Шаазгай “Маргааш маргааш. Чамд хэчнээн маргааш байх юм бэ? Би одоо ирж чадахгүй. Чи өөрөө мэд” хэмээн ихэд уурлан явж одов.

Бялзуухай барилгачин шаазгайгаар заалгаагүй, бас өөрөө барьж чадахгүй тул өнөөг хүртэл үүрээ барьж чадсангүй. Энд тэнд хэрэн хэсэж, үдэш орой айл өрхийн саравчинд шурган хоноглох болсон гэнэ.




Асуултад хариулж ярилцаарай.

- Бялзуухай үүр барих ажлаа хэдэн удаа маргааш гэж хойшлуулсан бэ?
- Ажлаа маргааш маргааш гэж хойшлуулсаар бялзуухай ямар байдалд хүрсэн бэ?
- Чамд бялзуухай шиг маргааш гэж хойшлуулдаг зан бий юү? Хэрвээ тийм бол ажлаа хойшлуулдаг зангаа хэрхэн өөрчлөх вэ?





Өөртөө хэрэгтэй, бусдад тустай зүйл хийхийн тулд өдрийн цагаа хуваарилъя. Дэвтэртээ доорх цагийг дуурайлган зураарай. Дараа нь цагаа хэсэгчлэн будаад юу хийхээ тэмдэглээрэй.



Одоо чин сэтгэлээсээ  
хийх л үлдлээ.  
Чи чадна!

Залхуу хүний маргааш олон  
Зальтай хүний дараа олон



Цаг хугацаа бол хүний ашигладаг зүйлсээс хамгийн үнэ цэнтэй нь юм. Хүмүүс цагийг алттай зүйрлэдэг. Цагийг үр ашигтай өнгөрөөж, эрдэм мэдлэг, их баялагтай болох нь чамаас л шалтгаална.

Цаг хугацаа хүнийг хүлээдэггүй. Тиймээс аливаа ажлыг хойш тавилгүй цагт нь хийж сурах нь чухал. Харамлах нь хүний муухай шинж боловч цагаа харамласан хүнийг уучилж болно.



## САЙН ҮЙЛИЙГ САХИЖ, МУУ ҮЙЛИЙГ ТЭВЧИХ ЁС

## 9. БУЯН, НҮГЭЛ

Сайн, муу аливаа үйлийг хүн бие, хэл, сэтгэлээрээ үйлддэг. Манай ард түмэн сайн, муу үйлийг буян, нүгэл гэж ялган нэрлэдэг. Үр хүүхдэдээ нүгэл хийж болохгүй, буян хийж бай хэмээн сургасаар ирсэн.



Эдгээр үгийн аль нь ижил утга илэрхийлэх вэ? Дэвтэртээ багцалж бичээрэй.

Сайн, саар, муу, эерэг, сөрөг, зөв, буруу, буян, нүгэл



Бие, хэл, сэтгэлээр үйлдэх сайн үйлийг “Буян” гэдэг. Харин бие, хэл, сэтгэлээр үйлдэх муу үйлийг “Нүгэл” хэмээдэг.

**Үг хэлээр үйлдэх дөрвөн муу үйл бий.** Үүнд:

1. Худал хэлэх
2. Хов зөөх
3. Ширүүн үг хэлэх
4. Дэмий чалчих

**Биеэр үйлдэх гурван муу үйл байдаг.** Үүнд:

1. Амьтныг цохиж зодох, амьтны амь таслах
2. Хулгай хийх
3. Биеэ буруу авч явах

**Сэтгэлээр үйлдэх гурван муу үйл бий.** Үүнд:

1. Хорлох сэтгэл
2. Хомхой сэтгэл буюу шунал
3. Буруу үзэл хамаарна.

Монголчууд бусдыг энэрэн хайрлаж, бусдад чадлынхаа хэрээр тус дэм болж амьдрахыг зорьж ирсэн сайхан уламжлалтай. Өвөг дээдэс маань дээрх арван муу үйлийг “арван хар нүгэл” хэмээн ихэд жигшин, цээрлэж ирсэн. Арван хар нүглийг хийхгүй, бусдад бие хэл, сэтгэлээрээ сайн үйл хийхийг “арван цагаан буян” гэдэг.





Ямар үйлийг нүгэл, ямар үйлийг буян гэдэг вэ? Тодорхойлолтыг ялгаж бичээрэй.

Нүгэл	
Буян	



Дараах сайн, муу үйлийг бие, хэл, сэтгэлээр үйлдэхийн аль нь болохыг ялгаж ярилцаарай.

- Бусдын амжилтад баярлах
- Хочлох
- Биеэ зөв авч явах
- Эелдэг үг хэлэх
- Байгаагаас илүү гоё ганган юмыг хүсэх
- Хэрэггүй юм ярьж цагаа үрэх
- Бусдын эд зүйлийг эзэнд нь мэдэгдэлгүй нууцаар авах

Хэлээр үйлдэх

Биеэр үйлдэх

Сэтгэлээр үйлдэх

- Оргүй зүйлийг үнэн мэт ярих
- Амьтан зовоох
- Атаархах
- Уурлах
- Бусдыг өрөвдөн хайрлах
- Өөрийн ээлж дарааллыг тайван хүлээх



Нүгэл, буяны тухай мэдлэгтээ тулгуурлан арван хар нүглийг арван цагаан буян болгож бичээрэй. Үүндээ дараах үгсийг ашиглаарай.

Амьтны амь хөнөөлгүй, аварч, өршөөх  
 Эелдэг үг хэлж, зөөлөн харьцах  
 Хов зөөхийг жигшиж, хүлээцтэй, тайван хандах  
 Бусдын зүйлийг зөвшөөрөлгүй авахгүй байх  
 Үнэнч, шударга байх  
 Эд зүйлд шунахгүй байх  
 Бусадтай сөргөлдөх, муу сэтгэлийг үл агуулан чин сэтгэлээс хандах  
 Хэрэггүй, тусгүй зүйл ярьж, цаг үрэхгүй байх  
 Аливаа зүйлийн эсрэг муу үзлийг тэвчиж, хүнлэг байх  
 Хэзээ, хаана, юу хийхээ бодож биеэ зөв авч явах

№	Нүгэл	Буян
1	Худал хэлэх	
2	Хов зөөх	
3	Ширүүн үг хэлэх	
4	Дэмий чалчих	
5	Амьтан цохиж зодох, амийг нь таслах	
6	Хулгай хийх	
7	Биеэ буруу авч явах	
8	Бусдыг хорлох	
9	Шунах	
10	Буруу үзэл	

ҮГ ХЭЛЭЭР ҮЙЛДЭХ САЙН, МУУ ҮЙЛ

## 10. ҮГ ШИДТЭЙ БОЛОВ УУ?



Чи ямар үг сонсоод баярлаж байсан бэ? Харин ямар үг сонсоод уурлаж байсан бэ?

Намайг баярлуулсан үг:

Намайг уурлуулсан үг:



Үг шидтэй болов уу?

Найз маань үеийн нөхдөөсөө өндөр юм. Хүүхдүүд түүнийг “Тэмээ” гэж хочилдог. Найз маань үүнд үнэхээр дургүй тул ангийнхандаа гомдоно. Тэгээд арын ширээн дээр толгойгоо гудайлган, уруу царайлаад сууж байв. Би очоод “.....” гэж хэлтэл түүний нүүрэнд инээмсэглэл тодров.





Тэр найздаа юу гэж хэлсэн бэ?



Ангиараа ярилцаад хэлж болох хамгийн тохиромжтой үгийг бичигцгээе.



Үгээр хүнийг баярлуулж, хүч тэнхээ өгч, амжилтад хүргэж, аз жаргалтай болгож болно. Мөн гомдоож, уурлуулж, хүсэл зоригийг нь мохоож болно. Иймээс үг бол маш шидтэй.



Ямар үгс хүнийг баярлуулж, сэтгэлийг баясгадаг вэ? Ямар үгс хүнийг уурлуулж, гомдоож, сэтгэлийг нь хямруулдаг вэ?

ээлдэг үг, урмын үг, хов үг, ерөөлийн үг, худал үг, магтаал үг, хараалын үг, бүдүүлэг үг, ширүүн үг, үнэн үг, сургамжийн үг, дэмий үг, гомдлын үг



Дээрх үгсийг хүснэгт зурж, ялган бичээрэй.

Хүнийг баярлуулж, сэтгэлийг баясгадаг үгс	Хүнийг уурлуулж, гомдоож, сэтгэлийг нь хямруулдаг үгс



Үгийг зөв байрлуулж, өгүүлбэр бүтээгээрэй.

хүнийг

болно

Үгээр

баярлуулж ч

гомдоож ч

болно

## 11. ХЭЛЭЭР ҮЙЛДЭХ САЙН, МУУ ҮЙЛ



Ямар үг хэлэхийг хэлээр үйлдэх сайн үйл, харин ямар үг хэлэхийг муу үйл гэх бол?



- Хэлээр үйлдэх дөрвөн сайн, дөрвөн муу үйл байдаг. Хэлээр үйлдэх дараах үйлүүдийг сайн, муугаар нь ялгаж бичээрэй.
- Ингэхдээ эсрэгцүүлж бичээрэй. Жишээ нь: хэрэгтэй, тустай үг хэлэх - дэмий чалчих гэх мэт.
- Дараа нь дасгалын хариугаа хоорондоо ярилцаарай.

Худал хэлэх	Ширүүн үг хэлэх	Ямагт үнэнийг өгүүлэх
Эвийг эрхэмлэж, аядуу зөөлөн үг өгүүлэх	Хэрэгтэй, тустай үг хэлэх	Эелдэг зөөлөн үг хэлэх
Бусдыг эвдрэлцүүлж буруугаар ойлгоход хүргэх үг хэлэх	Бусдад хэрэггүй зүйл ярьж, цагаа үрэх	

№	Хэлээр үйлдэх сайн үйл	Хэлээр үйлдэх муу үйл
1		
2		
3		
4		



## 12. ҮГ БОЛ БҮТЭЭХ, ЭВДЭХ ЧАДАЛТАЙ



Хэлээр үйлдэх сайн, муу үйлүүд ямар тустай, ямар хор уршигтай вэ?



### Үг бол бүтээх, эвдэх чадалтай

Ухаалаг утгат үг  
Уяруулж эвсүүлэх чадалтай  
Утгагүй чалчаа үг  
Уурлуулж гомдоох хортой  
Хэлэх үгийнхээ утгыг  
Хэзээд бодож ярь  
Хэрэггүй дэмий үгийг  
Хэнд ч бүү өгүүл  
Харшлах дэмий үгээр  
Хайран нэрээ хугалдаг  
Ашиг тусгүй яриа  
Ажилд саад болдог  
Ширүүн үг эвийг эвдэж  
Хорсол гомдлыг бий болгодог  
Ширүүн үг нөхрийг бухимдуулж  
Хэрүүл маргааныг дэгдээдэг

Уур хүргэх үг бүү хэл  
Муу үгнээс хэрүүл гардаг  
Худалчид бүү итгэ  
Ховчтой бүү хэлэлц  
Тэгэх ингэх гэж  
Тэнэмэл үгийг бүү дамжуул  
Буцах эзэнгүй үгийг  
Бусдад бүү хэл  
Найз сайн нөхөр боловч  
Наадаж хэлсэн хатуу үгнээс  
Хэрүүл маргаан үүсэж  
Хэвийн харилцаа муудна  
Саруул ухаант хүнд  
Сайн үг эрдэнэ мэт  
Үг үл мэдэх хүнд  
Үнэн үг шороо мэт



Д.Чойжилсүрэн “Сургаалын өглөг”-өөс



Шүлгийг уншаад доор өгөгдсөн үгс юунд хүргэдгийг ярилцаарай. Үүнд дээрх шүлэг тусална.

Ухаалаг үг, чалчаа үг, харшлах дэмий үг, ашиг тусгүй яриа, ширүүн үг, уур хүргэх үг, буцах эзэнгүй үг, наадаж хэлсэн хатуу үг

## 13. ХУДАЛД ҮНЭН ҮГҮЙ



Дараах зүйр цэцэн үгс ямар утгатай вэ?

Худалч хүн  
нөхөргүй  
Хувхай мод  
навчгүй

Худалчийг  
яриагаар нь таних  
Хулгайчийг мөрөөр  
нь барих

Хуурсаар хуурсаар  
худалч  
Хумсалсаар  
хумсалсаар хулгайч



### Дөрвөн чоно

Дөрвөн ишиг багштай болж, хичээлд суугаад нэлээд удаж гэнэ. Багш нь тэдний сурсан зүйлийг маргааш шалгана гэж хэлэв.

Тэд шалгуулахаар очих замдаа тоглож наадсаар шалгалтаасаа хоцорчихжээ. Багш нь ямар учраас хоцорсныг асуутал ишигнүүд сандран, бие бие рүүгээ харав.

Тэгтэл хамгийн том нь:

- Биднийг ирж явтал чоно тааралдаж, хадны ёроолд нуугдаж суугаад хоцорчихлоо гэв. Багш нь:
- Ойлголоо, би шалгалтаа эхэлье. Багшид нь шалгалтын ганц л даалгавар байна. Та нар тааралдсан чоноо зураарай гэв.

Ишигнүүд гайхсан ч даалгаврыг хийжээ.

Дараагийн өдөр багш нь “Та нар луу дайрсан чоно олон зүстэй болж хувирдаг шидтэй юм. Та нар айсандаа өөр өөр өнгөөр харсан байх” гэхэд ишигнүүд ихэд ичжээ.





- Дөрвөн ишиг яагаад ичсэн бэ?
- Тэд үнэнээ хэлж болох байсан уу?





Дараах үйлдлүүд зөв үү, буруу юу?

- 1 Хичээлийн дараа ангиа цэвэрлээд, дараа нь гадаа тоглоод оройтож харив. Тэгээд ээждээ “Хичээлийн дараа ангиа цэвэрлээд удчихлаа” гэж хэллээ.
- 2 Гэрийн даалгавраа хийлгүй ирээд багшид “Даалгавраа хийсэн. Гэхдээ дэвтрээ гэртээ мартчихаж” гэв.
- 3 Дандаа гоё, ганган зүйлээ гайхуулдаг найзууддаа “Манай ах ч гэсэн надад зөндөө гоё юм авчирч өгсөн” гэж худал ярив.
- 4 “Аав ээждээ гомдоллож байгаад шинэ хувцас авхуулаач” гэсэн найзынхаа үгийг охин дагахгүй гэж бодов.



Худал ярих гэж юуг хэлэх вэ? Худал хэлж болох уу?





Дараах өгүүлбэрийг уншаад худал ярихын хор уршгийг жагсааж бичээрэй.

Худал ярьдаг хүн бусдын итгэлийг алддаг. Хэлсэн үгэнд нь хүн итгэхгүй, найз нөхөргүй болно. Худалч хүний түр зуурын хэрэг бүтэвч цаашдын хэрэг нь бүтдэггүй болдог. Хожим өөрөө бусдад хууртагдаж ч мэднэ. Худалч байх нь олон гэмтэй.



Худал хэлсэн бол алдаагаа хэрхэн залруулах вэ? Ямар арга байна вэ?



Хэрэв чи худал хэлсэн бол чин сэтгэлээсээ гэмшээд, дараах зөвлөгөөг дагаарай.

- Үнэнийг тайван, эелдгээр хэлээд заавал уучлалт гуйгаарай.
- Дахиж худал хэлэхгүй гэж өөртөө амлаарай.
- Амлалтаа ямагт сахин биелүүлээрэй.



Дараах онч мэргэн үгсийн утгыг тайлбарлан ярилцаад, тэмдэглэн бичээрэй.

Худал хэлж мэргэн болохгүй  
Хулгай хийж баян болохгүй

Худалч хүний “нээрэн” олон  
Хуурамч хүний “хөөрхий” олон

Худалч хүн нөхөргүй  
Худгийн ус загасгүй

Нүд үнэнч  
Чих худалч





## 14. ХОВЛОВОЛ ГУТНА



“Хов” гэдэг нь хов хоосон гэсэн үгнээс гаралтай. Тэгэхээр хов зөөх гэдэг нь ямар утгатай бол?



### Ховч зараа

Сааралаа, Бороо нэртэй хоёр туулай найзалдаг байжээ. Зараа тэдэнд үргэлж атаархана. Нэг өдөр тэд ойд жимс түүж байлаа. Гэтэл Сааралаа модны мөчирт хөлөө гэмтээчхэв. Хөл нь өвдөж байсан учир тэр жимс сайн түүж чадахгүй байлаа.

Үүнийг анзаарсан Бороо саваа дүүргээд найзыгаа амрах зуур савыг нь сольчхов. Сэмхэн харж байсан зараа яаран гүйж Сааралаа руу очоод “Найз чинь чиний түүсэн жимсийг авчихлаа” гэжээ. Сааралаа найзаасаа “Чи миний савтай жимсийг авчихсан юм уу?” гэж асуув.

Тэгтэл Бороо тайвнаар инээж “Тиймээ, найз аа. Би өөрийнхөө савыг дүүргэчихсэн. Чинийх дундуур байсан болохоор чамд дүүргэж өгсөн юм. Чи саваа хар даа” гэв.

Сааралаа, зараа хоёр очиж үзвэл сав нь үнэхээр дүүрэн жимстэй байлаа. Зараа хов зөөсөндөө ичиж, сэмхэн явж одов. Харин Бороо, Сааралаа хоёр үүнээс хойш улам сайн найзууд болжээ.



- Зараа тэдэнд хов зөөсэн үү?
- Зараа яагаад хов зөөсэн бэ?



Зараа хов зөөсэн ч хоёр найз яагаад салаагүй вэ?



Дараах хоёр тохиолдлыг уншаад, хов мөн эсэхийг тодорхойлоорой.


№	Тохиолдол	Хорлох сэтгэлээр үнэнийг хэлсэн	Туслах сэтгэлээр үнэнийг хэлсэн	Хов зөөсөн
1	Асрал хичээл дээр сонирхолтой тоглоом авч ирээд тоглож байв. Энэрэл “Надад тоглоомоо түр өгөөч. Би нэг тоглочоод өгье” гэж гуйсан боловч өгсөнгүй. Гомдсон Энэрэл “Багш аа! Асрал тоглоомоор тоглоод байна” гэжээ.			
2	Асрал хичээл дээр сонирхолтой тоглоом авч ирээд тоглож байв. Энэрэл “Чи хичээлээ хий л дээ. Бусдад саад болоод байна шүү дээ” гэсэн боловч Асрал тоглосоор байв. Энэрэл тэгэхээр нь “Багш аа, Асрал тоглоомоор тоглоод байна” гэжээ.			



Найзууд чинь буруу зүйл хийвэл эхлээд заавал өөрт нь “болохгүй” гэж хэлээрэй. Тэгсэн ч найз чинь буруу зүйлээ болихгүй бол томчуулд хэлэх хэрэгтэй. Тэгвэл энэ хов биш, харин найзыгаа буруу зүйлээс хамгаалж буй хэрэг юм.



Найзыгаа ховловол юу болох вэ? Өөрсдийн санааг нэмж хэлээрэй.





Хүнийг далдуур муу хэлж, хүмүүсийг эвдрэлцүүлэх зүйл ярихыг “Хов зөөх” гэнэ. Монголчууд хов ярих, бас сонсохыг цээрлэдэг. Хов үг сонсвол хоёр биеэр нүүр тулан уулзаж, үнэн учраа ололцохыг эрхэмлэдэг. Дамын үг далан худал, зуурын үг зуун худал хэмээсэн ардын зүйр үгийг санаж яваарай.



Дараах онч мэргэн үгсээс нэгийг сонгож, утгыг тайлбарлан бичээрэй.

Хов үгийг хэлснээр  
Хоромхон зуурын хэрэг бүтэвч  
Хотол бүгдэд жигшигдээд  
Хойшдын хэрэг үл бүтнэ.  
Арга зальтан хов үгээр  
Амраг нөхдийг хагацуулах нь  
Алсдаа өөрт тусгүй бөгөөд  
Аливаа бүхэнд жигшигдэнэ.

Хоёр нохойн хооронд яс бүү хая  
Хоёр нөхрийн хооронд хов бүү хэл



## 15. ШИРҮҮН ҮГ СЭТГЭЛ ӨВТГӨНӨ



Зураг дээрх хүүгийн оронд байсан бол чамд ямар санагдах вэ?



### Ганцаарддаг болов уу?

Өөрийнх нь хүслээр болохгүй бол  
Өрөөл бусдад уурладаг  
Өөдгүй зантай нэгэн жаал  
Өрөөндөө ганцаараа сууна.  
Санаанд нь юмс таалагдахгүй бол  
Сайхан царай нь атиран улайгаад  
Саар муухай үгс урсгаад  
Сайн зангаа гэж орхино

Ухаандаа захирагдах уужим сэтгэлээр  
Уучлах, өршөөхийг ухуулаад ч нэмэргүй  
Уурласан сэтгэлээр хэнийг ч доромжилно  
Утгагүй үгсээр бусдыг буруутгана  
Түүнийг ирэхээр нь бид явчихна  
Тэгээд хөөрхий ганцаараа хоцорно  
Ганцаараа байгаад уйдаа юм уу  
Гаргасан алдаагаа ухаарах болов уу



- Хүү яагаад ганцаардах болсон бэ?
- Бусад хүүхэдтэй тоглохын тулд тэр цаашид яах хэрэгтэй вэ?



Дараах үгсийг **ууртай, ширүүнээр** хэлж үзээрэй.  
Ямар сонсогдож байна вэ?

баярлалаа

уучлаарай

ойлголоо

за,тэгье

сайн байна



Хатуу ширүүн үг хэлэх, дайрч доромжлох, хочлон шоолох, хараалын үг хэлэх зэргийг ширүүн үг гэнэ.

Эх хэл маань үгийн арвин их баялагтай. Бусдыг хүндэлж, хэлэх үгээ эерүүлэн, хүний сэтгэлийг баясгах олон сайхан үг хэлж хэвшээрэй.



- Дараах үгсээс ширүүн үгийн үр дагаврыг ялгаарай.
- Өөрийн санааг нэмж бичээрэй.

хэрүүл маргаан

хайр энэрэл

эв эе эвдрэх

баяр хөөр

өрөвдөх сэтгэл

гуниг гутрал

гоморхож гомдох

сэтгэл хямрах

сэтгэл баясах

атаа хорсол

бухимдаж уурлах



Дараах үгсийг эерүүлж бичээрэй.

► Эерүүлэх-зөөлөн,  
ээлдэг болгох


Жишээ нь : Битгий худлаа яриад бай. → Чи жаахан эндүүрээд/хэтрүүлээд байна.

- Чи дуугүй бай.

- Холд

- Миний юмыг өгөөч, чи.

- Хүний ярианд битгий оролцоод бай.



## 16. ДЭМИЙ ЧАЛЧИХ



Дэмий чалчих гэж юуг хэлэх вэ?

Чалчих гэдэг нь “чал, чал” гэсэн ус дуслах чимээг заасан үгээс гаралтай. Утга учиргүй үгийг дахин давтаж, нуршин хэлэхийг ийнхүү нэрлэдэг болжээ.



Нутаг усандаа “Ухаант мэргэн багш” хэмээн алдаршсан нэгэн хүн байжээ. Тэр багш дэмий ярьж, цагийг үр бүтээлгүй өнгөрүүлдэггүй байв. Нэг өдөр түүн дээр нутгийн хүн хүрч ирэн, амар мэндийг нь эрээд “Танд хэлэх зүйл байна” гэжээ. Тэгэхэд нь мэргэн багш:

-За байзаарай, хө. Хэлэх гэж байгаа зүйл чинь надад, чамд, эсвэл хэн нэгэнд хэрэгтэй юм уу? гэж асуув. Нөгөө хүн хэсэг бодоод:

-Үгүй, сайн бодвол энэ танд ч, надад ч, өөр бусдад ч хэрэгтэй биш л юм байна гэв. Тэгэхэд нь мэргэн багш:

-За, тийм байж. Тэгвэл тэр чинь ядаж үнэн зүйл үү? Чи өөрийн нүдээр харсан юм уу? гэхэд өнөөх хүн:

-Би өөрийн нүдээр хараагүй л дээ. Тиймээс үнэн, худлыг нь ялгаж мэдэхгүй байна гэхэд мэргэн багш:

-Тэгвэл чи тэр зүйлээ надад хэлэх хэрэггүй юм байна гэжээ.



Мэргэн багш тэр хүнээс юу юу гэж асуусан бэ? Түүний асуултуудыг ялгаж бичээрэй.



Мэргэн багш тэр хүний хэлэх гэсэн зүйлийг яагаад сонсоогүй вэ?



Мэргэн багшийн асуултаас дэмий ярих, чалчих гэж юуг хэлэхийг мэдэж болно. Дараах тодорхойлолтыг уншаад, та нарын бодолтой таарч буй эсэхийг ярилцаарай.



Өөрт болон бусдад ямар ч тус нэмэргүй, эцэстээ сайн үр дүн өгөхгүй зүйл ярихыг дэмий чалчих гэнэ.



Дараах тохиолдлуудаас аль нь дэмий ярьж буй хэрэг вэ? Дэвтэртээ ялган, дэмий яриа бол Д үсэг, дэмий яриа биш бол Б үсэг бичээрэй.

№	Тохиолдол	Д / Б
1	Нандин, Зулаа хоёр байрныхаа гадаах цэцэрлэгт уулзав. Нандин найздаа өчигдөр Нараад гомдсон тухайгаа ярьж тайвширлаа.	
2	Хоёр найз хөвгүүн бүтэн сайн өдрийг хамтдаа үр бүтээлтэй өнгөрүүлэхээр тохиролцов. Ингээд нэгнийдээ зочлов. Орой болж зочлон ирсэн найз нь гэртээ харих боллоо. Гэтэл тэд гэрийн даалгавраа ч хийгээгүй, хамтдаа угсарна гэсэн оньсон тоглоомоо ч угсарч амжаагүй байлаа.	
3	Монгол хэлний хичээл орж байв. Арын ширээний Ану, Саруул хоёр маргааш болох баярт юу өмсөх, юу авч очих талаараа тасралтгүй шивнэлдэв. Урд нь суусан Анар уншиж байгаа эхээ ч ойлгосонгүй.	
4	Нартай, дулаахан өдөр хөршийн өвөө нар гадаа саравчинд өдөржин шатар тоглож, хууч хөөрдөг. Тэд үр хүүхдүүдийнхээ тухай ярина. Бас ойрын өдрүүдэд юу хийх талаараа бие биедээ ярьж, сэтгэл санаагаа хуваалцдаг.	



Дэмий чалчих нь өөрийн болон бусдын үнэтэй цагийг үрдэг. Дэмий үг ам дамжсаар цуурхал болно. Цуу үг, цуурхал гэдэг нь хадны цуурайтай адилтган нэрлэсэн нэр юм. Дэмий үг ярьж, сонсож алтан цагаа бүү үрээрэй.

Харин сэтгэл санаагаа хуваалцаж, үзэл бодлоо зөвлөж шинэ сонин мэдээлэл солилцох нь “дэмий чалчих” яриа биш.

Хамгийн гол нь:

- зөв цагт
- бусдад саад болохгүй
- эмх цэгцтэй
- утга төгс, уран яруу
- товч, тодорхой ярьж байхыг хичээгээрэй.



Хэлний дөрвөн муу үйлийг санаж, нэрлэнэ үү.




Худал хэлж, хов зөөж, ширүүн үг хэлж, дэмий ярихгүй бол үг хэл чинь эелдэг зөөлөн, үнэн, тустай байх болно. Хэлж буй үгээр нь хүнийг ямар хүн болохыг нь таньж болдог. “Үг алдвал барьж болдоггүй, Үхэр алдвал барьж болдог” учир хэлэх үгээ байнга бодож байгаарай.

Ам алдвал барьж болдоггүй  
Агт алдвал барьж болдог

Үг сөрвөл хэрүүл болдог  
Үүл сөрвөл хур болдог

## 1. ХҮН ХҮНДЭЭ ТҮШИГ



Ойр дотнын хүмүүсийнхээ нэрийг дэвтэртээ бичнэ үү.



Хүн бүр бие биедээ түшигтэй. Тэд бидэнд ямар тустай вэ?

Гэрэл чийдэн асахгүй бол засдаг.

Биднийг хамгаалдаг.

Бидний орчныг цэвэр цэмцгэр байлгадаг.

багш

үйлчлэгч

цагдаа

цахилгаанчин

тогооч

эмч

Идэх хоол, уух ундыг маань бэлддэг.

Өвдсөн үед биднийг эмчилдэг.

Бидэнд эрдэм ном зааж сургадаг.






Чи тэднийг хэрхэн хүндэлдэг вэ? Өөрийн хийдэг үйлдлийг ялгаж, дэвтэртээ нэмж бичээрэй.

- Хүндэтгэн мэндэлдэг.
- Тэдэнд саад болдоггүй.
- Баярласнаа илэрхийлдэг.
- Хийсэн зүйлийг нь эвдэж, муухай болгодоггүй.



Аль үйлдэл нь хүндэлж буйг харуулах вэ?





Дараах асуултын дагуу ангиараа ярилцаад, хамтдаа нэг хариу гаргаарай.

Хүнийг хүндлэхэд		
Юу хэлэх вэ?	Юу хийх вэ?	Юу бодох вэ?



Аль зүйр цэцэн үг нь “Хүн хүндээ түшиг” гэдгийг илэрхийлж байна вэ?



Хүн хэзээ ч цор ганцаар амьдарч чаддаггүй. Заавал бусдын тус дэмийн хүчээр амьдардаг. Бидний эдэлж хэрэглэж буй бүх зүйл бусдын хөдөлмөр, сэтгэлээр бүтсэн. Тиймээс бусдыг ялгаварлалгүй адил тэгш хүндэлж, эв найртай амьдрах нь хамгаас чухал.

## 2. ЭХИЙН ЭЛБЭРЭЛ



Зураг дээр юу харагдаж байна вэ?



### Эхийн ач

Залгих хоолны шимтэйг  
Заяасан хүүхдэдээ өгч  
Уух ундны дээжийг  
Урьдаар та нарт өгч  
Өсөх үрээ тэжээж  
Өлсөж ядарч явлаа  
Эгмээс чинь татаж  
Эрийн цээнд хүргэсэн  
Эрхэм ачийг санацгаа  
Хүзүүнээс чинь татаж  
Хүний зэрэгт хүргэсэн  
Хүндэт ачийг нь бодоцгоо

Наран шиг гэгээн ухаант

Навч шиг дэлгэр сэтгэлт

Сайхан хатан эхийнхээ

Санааг бүү чилээ

“Монголын Нууц Товчоо”-ноос



“Эхийн ач” шүлэгт эх хүн үр хүүхдийнхээ төлөө юу хийдэг гэсэн байна вэ? Хариултад тохирох хэсгийг эхээс олоорой.



Ээж чинь чамайг нялх, бага байхад чиний төлөө юу хийдэг байсан бэ? Одоо чиний төлөө юу хийдэг вэ?

Нялх байхад

Бага байхад

Одоо



Чи ээждээ талархсанаа яаж илэрхийлдэг вэ?

А Талархсанаа байнга хэлдэг.

В Гэрийн ажилд тусалдаг.

Б Үгэнд нь ордог.

Г Хичээл сурлагадаа шамддаг.



Ээж минь надад ямар үед баярлах бол?  
Ээжийг минь ямар үг баярлуулах бол?



Ээжийгээ баярлуулахын тулд юу хийх, ямар байх ёстой вэ?  
Ангийнхантайгаа дэлгэрүүлж ярилцаарай.



Ангийн найзууд чинь ээжийгээ яаж баярлуулдаг вэ?



Хариултуудаа нэгтгэн дүгнээрэй.

Бид ээжийгээ баярлуулахын тулд ..... хэрэгтэй.

### 3. ЭЭЖИЙНХЭЭ ҮГЭНД ОРООРОЙ



Зураг дээрх хүүхдэд юу тохиолдсон бол?



#### Чих

Давааг тэшүүр аван гэрээс гарахад ээж нь “Гадаа хүйтэн байна шүү. Миний хүү малгайныхаа чихийг буулгаарай” гэж хэллээ. Хүү “За, ээж ээ” гэж явуут дундаа хайхрамжгүйхэн хэлээд, хаалгаар гармагц ээжийнхээ хэлснийг мартаж орхилоо. Гулгахаар яарч, гол руу хөлийн хурдаараа гүйв. Толь шиг тунгалаг мөсөн дээр тэшиж байгаа хүүхдүүдийг харан бүр ч их яарлаа. Санд мэнд тэшүүртэй шаахайгаа хөлдөө өмсөх үед ээж нь нэг юм хэлж байсан санагдав. “За байз, юу гэсэн билээ?” гэж бодсон боловч халти сонсоод өнгөрсөн болохоор санаанд нь орсонгүй. Ээжийнхээ юу хэлснийг санах гэж хичээсэн ч үгүй.

Даваа хүүхдүүдтэй гулгаж, хоёр гурав тойров уу, үгүй юү өрөөсөн чих нь бахиар хавчсан мэт час хийгээд явчихлаа. Тэр даруй л ээжийнх нь “Малгайныхаа чихийг буулгаарай” гэж байсан нь санаанд орлоо.

Ш.Цэнд-Аюуш



Ээжийнхээ хэлсэн үгийг анзаараагүйгээс Даваад юу тохиолдсон бэ?



(А)



(Б)



(В)



Аав, ээжийн үг, захиас яагаад үргэлж зөв байдаг юм бол? Чи юу гэж бодож байна?

## 4. УУЛ ШИГ ТҮШИГТЭЙ АЧТАН



Зургийг ажиглаарай. Юуг харуулсан зураг байна вэ?



Аав, өвөө чинь чамайг нялх, бага байхад чиний төлөө юу хийдэг байсан бэ? Одоо чиний төлөө юу хийдэг вэ?

Нялх байхад

Бага байхад

Одоо



Аав нь охиноо үржүүлэхийн хүрдээ цээжилсэнгүй гэж зэмлэжээ. Гэтэл охин уурлан, хөнжилдөө шурган хэвтээд “Намайг загнадаг муухай аав” гээд уйлав. Хэнийх нь зөв бэ? Яагаад?



Долоон настай нэгэн хүү аавынхаа тухай ингэж бичжээ. Үүнээс санаа аван аавдаа талархлын зурвас бичээрэй.



Миний  
хамгаалагч



Хөлийг минь  
дулаацуулагч



Гэр дүүргэгч



Миний багш



Биднийг  
тайвшруулагч



Миний нууцыг  
хадгалагч



Миний хамгийн  
сайн найз

Аав аа,  
та бол



Дэвтэртээ ялгаж бичээрэй.



Аавыгаа баярлуулах үг: Аав аа, та ядрав уу? Цай уух уу?



Аавыгаа баярлуулах үйлдэл: .....



Чин сэтгэлээсээ хүндлэх: .....

## 5. ААВЫН АЯГА



Танай гэрийнхэн аавыгаа, гэрийн эзнийг, өвөөгөө хэрхэн хүндэлдэг вэ?



Монголчууд аяганд амны хишиг, буян тогтдог хэмээн бэлгэдэж, эрхэмлэн дээдэлдэг. Монгол хүн бүр аягаа тусгайлан бэлтгэсэн жижиг уутанд хийн, авч явдаг байсан. Ингэснээр ариун цэвэр сахиж, өвчин эмгэгээс сэргийлдэг байжээ. Үүний цаана бас буян хишгийн саваа бусдад хамаагүй хэрэглүүлэхгүй гэсэн санаа бий.

Монголчууд мөн гэрийн эзэн, аавын аягыг ихэд эрхэмлэдэг. Аавдаа цай хоолныхоо дээжийг хийж, хоёр гардан барьдаг.




- Монголчууд гэрийн эзэнд хоол, цайг яаж өгдөг ёстой вэ?
- Монгол хүн яагаад өөрийн аягатай байсан бэ?
- Танай гэрийнхэн цай, хоолны дээжээ хэнд эхлэн барьдаг вэ?



Аавынхаа эдэлж хэрэглэдэг, дээдэлдэг бусад зүйлийн талаар ярилцаарай.



- Малгайг газарт тавьдаггүй. Мөн дээш нь харуулан тавьдаггүй.
- Бүсийг эвхэлгүй задгай орхидоггүй.
- Дээлийн энгэрийг түрүүлгээ харуулж тавьдаггүй, заавал эвхэнэ. Авдар, шүүгээндээ хийж цэвэрхэн хадгална.





Аав, өвөөгөө хэрхэн дээдэлдэг талаарх жишээнүүдээ цуглуулж, ангилаарай.

Хоол цайны ёс

Хувцас хэрэглэл

Хэлж болохгүй үгс

## 6. ЭЦЭГ ЭХИЙН АЧ



Хэн үүнийг хийдэг вэ? Эргэн санаж, дэвтэртээ нөхөж бичээрэй.

Намайг ..... минь төрүүлсэн.

Намайг ..... минь хөтөлж хөлд оруулсан.

Надад ..... минь үг зааж ярилцсаар хэлд оруулсан.

Өвдсөн үед минь ..... намайг асардаг.

Уйлсан үед минь ..... намайг аргаддаг.

Өлссөн үед минь ..... надад хоол өгдөг.

Даарсан үед минь ..... хувцсыг минь авчирч өмсүүлдэг.

Уруу царайлсан үед ..... надад урам өгдөг.

Яагаад гэдэг асуултын учрыг ..... тайлбарлаж өгдөг.

Хичээлээ ойлгохгүй үед ..... тайлбарлаж өгдөг.



Зураг дээр хүний амьдралын ямар үеүдийг харуулсан байна вэ?



Нялх, бага байхад чинь хэн, хэн чамайг асарч, халамжилж, тусалдаг бол? Тэднийгээ санаж бичээрэй.

Намайг нялх байхад

Намайг бага байхад




Хэн насан туршид чинь чиний төлөө байх бол?

## 7. ЭВСЭГ ГЭР БҮЛ



Хөрш айл байж гэнэ. Нэг айлд нь хэрүүл маргаан тасрахгүй. Харин нөгөө айл нь эвтэй найртай амьдардаг ажээ.

Нэг өдөр эв муутай айлын гэрийн эзэн хөршийндөө зочлон, цай ууж суув. Гэтэл гал тогооноос түлэнхий үнэр ханхалжээ. Гэрийн эзэгтэй сандран “Би гал дээр тавьсан хоолоо мартчихсан байна шүү дээ, миний буруу боллоо” гэж уулга алдав. Энэ үед охин нь “Ээж ээ, би гал нэмчихсэн юм. Миний буруу” гэлээ. Тэгтэл эмээ нь “Би гал тогооны өрөөнд байсан атлаа анзаарсангүй. Охины минь буруу гэж юу байх билээ, миний л буруу боллоо” гэв. Гэрийн эзэн тайвнаар “Зүгээр дээ, хоол түлэгдээ л биз, санаа зоволтгүй” хэмээн гэрийнхнээ тайвшруулав. Хөрш нь тэдний эвтэй найртай байдгийн учрыг сая ухаарчээ.



Хоол нь түлэгдэхэд тэд юу гэж хэлсэн бэ?

Ээж нь

Эмээ нь

Охин нь

Аав нь



Хоёр хөршийн нэг нь эв найртай аж төрдгийн учир юу вэ?



## 8. ГЭР БҮЛЭЭ ХЭРХЭН ХҮНДЭЛЖ, БАЯРЛУУЛАХ ВЭ?



Эдгээрээс чи алийг нь хийдэг вэ? Хийдэг зүйлээ зураг дээр дугуйлж тэмдэглэнэ үү.



Аав, ээж, гэрийнхнээ хэрхэн бие, хэл, сэтгэлээрээ хүндлэх вэ?  
Ялгаж бичээрэй.

Үгээрээ	
Биеэрээ	
Сэтгэлээрээ	

## 9. ХҮНДЛЭХ САЙХАН



Чи алийг нь хийдэг вэ?



Хаалга онгойлгож  
өгөх



Ахмад хүнд суудал  
тавьж өгөх



Настай хүний үгийг  
хүлээцтэй сонсох



Мал эргүүлж өгөх



Ирсэн зочинтой мэндлэх



### Өндөр болоорой!

Би аавтайгаа хамт автобусанд явж байлаа. Хүн цөөхөн тул бид хоёр хоёулаа сандал дээр сууж явав. Тэгтэл хүнд тортой зүйл барьсан нэг эмээ ороод ирлээ.

Би “Эмээ, та ийшээ суу” гээд бушуухан босов. Эмээ толгойг минь илснээ “Ямар сайн хүү вэ, өндөр болоорой” гээд чихэр өглөө. Харин аав “Бусдыг хүндэлдэг ухаантай хүү шүү” гээд духан дээр минь үнсэв.

Өндөр настнаа хүндэлбэл өдөр болгон ийм гоё үг сонсох болов уу? Бас тэдний хэлснээр өндөр болох болов уу?



- Өвөө, эмээ нарт суудал тавьж өгөхөд тэд юу гэж хэлдэг вэ?
- Чи танихгүй өвөө, эмээ нарыг хүндэлж, тэдэнд тусалдаг уу? Настанд тусалж, баярлуулсан жишээгээ ангидаа ярилцаарай.



Бусдыг хүндлэхэд ямар санагддаг вэ?



## 10. НЭГ АНГИЙНХАН



Ангийн найз нартайгаа бид хэрхэн харилцдаг вэ? Өөрсдийн хийдэг үйлийг дэвтэртээ тэмдэглээд, нэмж бичээрэй.

- Өдөр бүр мэндэлдэг.
- Ярьж байхад нь үгийг нь тасалдаггүй.
- Бие биедээ ширүүн үг хэлдэггүй.
- Бие биеэ шоолж гомдоодоггүй.
- Эелдэг, зөөлөн харилцдаг.
- Баярлалаа, уучлаарай, болох уу зэрэг эелдэг үгсийг байнга хэрэглэдэг.
- Бие биедээ байнга тусалдаг.



### Нэг ангийнхан



Хичээлийн шинэ жил эхлэхэд ангид дүрсгүй ишиг, даруухан хурга, тайван ботго, сайрхуу бардам унага, ааш нь олддоггүй тугал иржээ. Сэрх багш тэдэнд:

“Та нар нэг ангийнхан. Сурч дадсанаараа бүү аашил. Бие биеэ хүндэлж, ойлгож, уужим өгөөмөр сэтгэлээр хандаарай. Үгүй бол хамтдаа сурч чадахгүй шүү” гэж захижээ. Гэрээсээ дөнгөж гарсан гэнэн жаахан тэд Сэрх багшийн үгийг сайтар ухаарч ойлгосонгүй. Эхний хичээлийн завсарлагаанаар л дүрсгүй ишиг цовхорч яваад тугал найзынхаа бэхийг асгаж орхисноо анзаарсангүй. Тоох ч үгүй алга болсонд нь тугал гомдоод мөөрч гарав. Ботго цочин босохдоо хурга руу тургичихлаа. Ботгоны шүлсэнд будагдсан хурга ичиж, яаран сандран хашаа руугаа гүйв. Борхон ботго уучлал гуйж, бусдаас ичсэн хургыг авч ирэхээр араас нь гарлаа. Омог бардам унага аль хэдийн тойрон давхиад, шоолон сонжин байв.

Сэрх багшийг орж ирэхэд урсаж дууссан бэхээ харж, уучлал гуйсангүй гэж уурласан тугал, унага хоёр л үлдсэн байлаа.

Дараа өдөр нь Сэрх багш “Таарч тохирохгүй, таалж нэгнийгээ хүндлэхгүй бол ганц ганцаараа хичээлээ хий дээ” гэлээ. Тусдаа гэрт ганцаараа суух нь тэдний хэнд нь ч сайхан байсангүй. “Маргааш багшаас гуйж, магад биесээ хүндлэхээ амлая” гэж төл бүр бодоод түргэхэн маргааш болохыг хүлээжээ.




- Ишиг яах ёстой байсан бэ?
- Ангид үүссэн хэрэгт хэн хэрхэн хандах ёстой байсан бэ?



Тэд цааш хэрхэх бол? “Нэг ангийнхан” эхийг үргэлжлүүлж зохиогоорой.



Танай ангийн хүүхэд бүр аав ээжийн хайртай хүүхэд, ах эгчийн сайн дүү. Бүгд өөр өөрийн хүсэл, сонирхол, авьяас чадвартай. Эрдэм номд шамдан суралцаж, эрхэм сайн хүн болох нэгэн зорилготой. Бүх хүүхэд бусад хүнээс эелдэг зөөлөн ааш, урмын үг, хайр энэрлийг хүсдэг. Инээмсэглэсэн харц, энхрийлсэн үг, хэрэгтэй үед нь хийх тус дэмийг хүснэ. Өөрт чинь хэрэгтэй, тустай бүхэн бусдад адилхан чухал. Бусдаар хүндлүүлэхийн тулд өөрөө бусдыг хүндэлж байх хэрэгтэй.



- Дараах үйлдлээс алийг нь ангийн дүрэмдээ оруулах вэ?
- Өөрсдийн хүсэж, бодсон санааг нэмж бичиж, зураарай.
  - Ангиараа хамтран бусдыгаа хүндлэх “Ангийн дүрэм”-ээ шинэчлэн зохиогоорой.



Бид бие биедээ тусална.



Нэгнийхээ юмыг асуулгүй авахгүй.



Ярих, үг хэлэхдээ гараа өргөнө.



Бид хичээлдээ анхаарна.



Бид бие биедээ эелдэг хандаж, ширүүн үг хэлэхгүй.



Багш ангиас гарсан ч үймүүлэхгүй, хажуугийн ангид саад болохгүй.



Бид бусдадаа саад болохгүй, анхаарлыг нь сарниулахгүй байна.



Бусдыг ярьж байхад таслахгүй, анхааралтай сонсоно.



Маргаж, зөрөлдвөл уураар биш эвээр шийднэ.



Бид хэнийг ч дээрэлхэж, гадуурхахгүй.



Бид хэнийг ч хочилж шоолохгүй.



Хичээл дээр багшийн зөвшөөрлөөр ярилцана.

## 11. ЭНГҮЙ ИХ АЧТАН



Ямар ажил мэргэжилтэй хүмүүсийг харуулсан зураг вэ?



Дараах зураг бүхий бичвэрийг уншаад, энэ бүхнийг хэн хийдгийг хэлээрэй.

**АБВ/123** заагч,



эзэмшигч,



урам зориг өгөгч,



-тэй зөвлөгч,



-ыг таслагч,

???

-д хариулагч,



засагч, зураач,



миний зөвлөгч,



эмхлэн цэгцлэгч,

**1+2**

**3-1**

аргыг мэдүүлэгч



Эхийг уншихдаа тохирох үгийг дэвтэртээ нөхөж бичээрэй.

### Багшдаа баярлалаа

Өнөөдөр би гүйж яваад уначихлаа. Өвдсөндөө уйлах шахав. Гэтэл багш өвдгийг маань зөөлөн илээд, үлээж өглөө. Өвдөг маань гэнэт өвдөхөө больчхов. Гэвч би багшдаа “Баярлалаа” гэж хэлээгүй юм байна. Тэгээд багшдаа талархлын үгээ бичье гэж шийдлээ.

Багш аа, та бол хамгийн сайн багш. Та:

Надад .....

Найзууд шиг .....

Уйлбал .....

Урам зориг өгдөг.  
 ..... зааж сургадаг.  
 Зөндөө сайхан үлгэр .....  
 Хамт .....  
 Хүсэл мөрөөдлийг минь дэмждэг.  
 Буруу юм хийвэл .....  
 Бүр заримдаа ээж шиг минь .....  
 Баярлалаа, багш аа. Би заасан бүхнийг тань сайн сурна аа.

**Нөхөх үгс:** ярилцдаг,  
 тусалдаг, аргаддаг,  
 сургадаг, ярьдаг, тоглодог,  
 уучилдаг, эрхлүүлдэг



“Талархлын алхаа” тоглоом тоглоцгооё.

Ангараа эгнэж зогсоод, хүүхэд бүр хэнд, яагаад талархаж байгаагаа хэлээд, урагш алхана. Бүгд хэлж эгнээнээс гарсан үед тоглоом дуусна. Хэн нэгэн найз нь хэлж чадахгүй удвал тусалж болно шүү.

Багшдаа баярлалаа.  
 Яагаад гэвэл,  
 .....

Ахдаа баярлалаа.  
 Яагаад гэвэл,  
 .....

Найздаа баярлалаа.  
 Яагаад гэвэл,  
 .....

## 12. ТАЛАРХАЛ



Хүн болгоны сонсох дуртай үг гэж бий. Ямар үг гэж бодож байна вэ? Сэдэвтэй холбон бодож хариулаарай.




**Талархал:** Хүн ямагт бусдын ачийг санаж талархах сэтгэлтэй явах хэрэгтэй. Бусад хүний ач тусад баярласан сэтгэл, тэрхүү сэтгэлээ илтгэх үг хэллэг, үйлдлийг талархал гэнэ.



Цэгийн оронд ямар үг тохирох вэ?



Энэрэл сургууль руугаа яаран гүйнэ. Учир нь хичээлийн цаг тун дөхсөн байлаа. Тэр яарсан ч замын голоор гүйсэнгүй. Явган хүний гарц

дээр хүлээн зогслоо. Тэр замын гарц  -гүй байсан юм.

Тэгтэл нэг машин зогсон, түүнд зам тавьж өгөв. Энэрэл талархсанаа илэрхийлж, ..... гэж хэлээд гараа даллалаа. Жолооч ах ч инээмсэглэн толгой дохив.



Дараах асуултын дагуу ярилцаарай.

- Энэрэл жолооч ахад юу гэж хэлсэн бол?
- Жолооч ах яагаад инээмсэглэсэн бэ?



Жолооч ахад талархан хэлж болох үгсээс гурвыг сонгоорой. Яагаад тэдгээр үгсийг сонгосноо тайлбарлаарай.

- Ах аа, баярлалаа.
- Баярласан шүү, ах аа.
- Ёстой сайн ах юм аа. Гялайлаа.
- Хичээлээсээ хоцрохгүй ээ, ах аа.
- Би их яарч байсан шүү, ах аа.

▶ талархах = тал өгөх





Баярлаж, талархсанаа хэрхэн хэлэх вэ?

Үеийн нөхдөд

Ахмад хүнд

Маш их баярлалаа.

Ёстой баярлалаа.

Үнэхээр баярлаж байна.

Гялайлаа.

Баярлалаа.

Их баярлалаа.

Таны ачийг мартахгүй

Чин сэтгэлээсээ баярласан шүү.

Та туслаагүй бол яана аа.

Тусалсанд тань үнэхээр баярлаж байна



Талархлын үг сонсох үед чамд ямар санагддаг вэ?


- |                                   |                              |
|-----------------------------------|------------------------------|
| 1 Хүнд дахин тусалмаар санагддаг. | 4 Тэр хүн дотно санагддаг.   |
| 2 Өөртөө итгэлтэй болдог.         | 5 Найздаа хэлмээр санагддаг. |
| 3 Өөрийн эрхгүй инээмсэглэдэг.    | 6 Сэтгэл сайхан болдог.      |



- Талархлын дэвтэр” нээгээрэй.
- Гэр бүлийнхнийхээ хэлдэг талархлын үгийг бичээрэй.




Манай гэр бүлийн талархлын үг





Чи ямар үед хамгийн их баярладаг вэ? Баярласан үедээ яадаг вэ?



### Бэлэг сонгосон нь

Зуны амралт эхэллээ. Ананд, Сараа, Сондор гурвын гэрээс хүн ирж амжаагүй тул хүүхдийн баярыг тэд дотуур байрандаа өнгөрүүлэхээр болжээ.

Тэд үлгэрийн шидтэн гарч ирээд, бэлэг өгдөг ч болоосой хэмээн ярилцаж суулаа.

Гэнэт гайхмаар зүйл болж, тэдний өмнө гэнэт үлгэрийн шидтэн гарч ирэв. Шидтэн тэднийг хүссэн нэг, нэг зүйлээ хэлээрэй гэв. Тэд итгэж ядна. Ананд улаан машин, Сараа ганган гутал, харин Сондор үлгэрийн ном хүслээ. Хэлж дуусаагүй шахам байтал алган дээр нь тоглоомын машин, гутал, ном буугаад ирэв.

Ананд “Хөөх, ямар гоё машин бэ?” хэмээн хөөрөн баярлалаа. Сараа гоёмсог гутлаа өмсөж үзээд “Яг таарч байна” гээд инээмсэглэв. Харин Сондор “Зунжингаа унших сайхан номтой боллоо. Их юм мэддэг болно доо. Гялайлаа” гэлээ.

Шидтэн гарч ирсэн шигээ гэнэт алга болов. Гэтэл Сондорын гарт л бэлэг нь үлдэж, Ананд, Сараа хоёрын бэлэг алга болсон байлаа.





Хүүхдүүд бүгд баярласан. Гэхдээ шидтэн яагаад Сондорын бэлгийг үлдээсэн бэ? Сурагч хүний хамгийн чухал ажилтай холбон бодож хариулаарай.

- а. Ном гуйж, баярласнаа хэлсэн учраас
- б. Баярлалаа гэж хэлсэн учраас
- в. Хүүхдийн баяр учраас



Баярласнаа биеэрээ яаж илэрхийлэх вэ?

Баярлалаа!

Баярлалаа!



Хүмүүсийн хийсэн ач тусын хариуд баярласан сэтгэлээ илэрхийлсэн үгс заавал хэлж хэвшээрэй. Харин чамд хариу хэлсэн талархлын үгийг нь -тээ бичиж, ангийнхандаа танилцуулаарай.



Энэ хичээлээс ойлгосон зүйлээ санаж бичээрэй.



Бусдад талархаж байгаагаа:

- сэтгэлийн үгээрээ
- хүндэлж, туслах үйлээрээ харуулж байгаарай.

Баярлаж талархсан сэтгэлийн үг сонссон хүн өөрт чинь ямагт баярладаг.

## 13. УУЧЛАЛ



- Чи бусдыг амархан уучилдаг уу?
- Бид хэнийг, ямар үед уучлах ёстой вэ?
- Чиний төлөө байдаг, чамд байнга санаа тавьдаг хүмүүст гомдон уурлаж, уучлахгүй байж болох уу?



Бусдыг уучлахгүй бол юу болох бол?



### Санаа амарсан нь

Хичээл тармагц ангийнхан хөл бөмбөг тоглохоор уралдан гүйцгээлээ. Харин Тэлмэн ганцаар уруу царайлан явна. Эгшиглэн түүнээс учрыг нь асуулаа.

- Чи яагаа вэ? Чамд юу тохиолдоо вэ? гэхэд Тэлмэн,
- Завсарлагаанаар багш намайг цаасан онгоц шидсэн гэж загнасан. Тэгээд “Ангийн дүрэм” сэдэвтэй зохион бичлэг бич гэсэн гэхэд Эгшиглэн,
- Манай багш сайн хүн шүү дээ. Чи сайн тайлбарлаж хэлсэн юм уу? гэж асуув. Тэлмэн хариуд нь,
- Уг нь би шидээгүй юм аа. Үнэнийг хэлбэл Гэрэлт найз маань гомдох болов уу гээд “Би шидээгүй” л гэж хэлсэн гэлээ.

Яг энэ үед “Тэлмэн, нааш ир дээ” гэж дуудав. Эргээд харвал багш нь байлаа.

- Багш аа, би шидээгүй шүү дээ гэж Тэлмэнийг хэлэхэд багш нь,
- Гэрэлт Чимэгээ рүү цаасан онгоц шиджээ. Та хоёр их адилхан харагддаг шүү дээ. Би андуурчихжээ. Намайг үнэхээр уучлаарай гэв. Тэлмэн “Зүгээр ээ, багш аа” гээд царайд нь инээмсэглэл тодорлоо.



- Тэлмэн яагаад уруу царайлсан бэ?
- Багш нь уучлал гуйхад Тэлмэнд ямар санагдсан бэ?



Эгшиглэн, Тэлмэн хоёр багшийг уучлал гуйгаад явсны дараа юу ярих бол?



Бусдын сэтгэлийг гонсойлгож, гомдоосон бол “Уучлаарай, өршөөгөөрэй” хэмээн чин сэтгэлээсээ уучлал гуйгаарай.

## МОНГОЛ ҮНДЭСНИЙ ДЭЭЛ, ХУВЦАС

## 1. БОРХҮҮГИЙН ДАХ



- Зураг дээрх хүн ямар хувцас өмссөн байна вэ?
- Өмссөн хувцсыг нь юугаар хийсэн байна вэ?



## Борхүүгийн дах

Борхүү арван настай. Тэр малд нүдтэй, эртэч хүү. Тал нутагт урин хавар аль хэдийн ирсэн үе. Аав нь Борхүүд “Сумын төв орох яаралтай ажилтай боллоо. Тэнгэр муухайрах шинжтэй байна шүү. Миний хүү адуу малаа ойр тогтоогоорой” гээд явав.

Удалгүй тэнгэр харанхуйлж, их цас орлоо. Борхүүд аавынх нь “Салхи шуурга гарвал дахаа аваад, нөмөр нөөлөгтэй, дулаан газар адуугаа тогтоож байгаарай” гэсэн үг санаанд нь оров. Тэгээд үстэй дээлээ өмссөн, дахаа авч, адуу руугаа давхин, адуугаа тогтоожээ. Бүрэнхий болоход аав нь ирээд “Миний хүү дахаа аваагүй бол осгох байж” гээд хүүгээ үнэрлэн бахархлаа.



- Хүү ямар дээл хувцас өмсөж гарсан бэ?
- Хүү тэр хувцсыг өмсөж гараагүй бол яах байсан бэ? Яагаад?



Аль улиралд ямар дээл хувцсыг өмсдөг вэ?



тэрлэг



үстэй дээл




хүрэм




хантааз




дах




өвөл



хавар



зун



намар



Нялх хүүхдийн дээлийг баривч гэдэг.



Ямааны нэхийг үсийг нь гадагш харуулж хийсэн, хүйтний улиралд дээлийн гадуур өмсдөг хувцсыг дах гэнэ.




Монголчууд ямар дээл, тэрлэгийг хэзээ, хаана өмсдөг вэ?

Энгийн дээл, тэрлэг	Ханцуйгүй, гоёлын дан дээл	Хурган дотортой дээл	Гоёлын торгон дээл	Хүрэм
------------------------	----------------------------------	-------------------------	-----------------------	-------



Өөрийнхөө дээлийг зураарай.



Монголчууд улирал, цаг агаартаа тохируулж олон янзын дээл өмсдөг. Өвөл үстэй дээл өмсөж дээлийн гадуур хүрэм, дахыг давхарладаг. Өвлийн хүйтэнд алс явах, адуу манах зэрэгт дах авч явдаг. Харин зун дан дээл, тэрлэг өмсөнө. Түүнчлэн хурим, төгсөлтийн баяр, цагаан сар, наадам зэрэг баяраар янз бүрийн хээтэй, хээгүй торгон дээлээр гоёдог.

# ӨВӨГ ДЭЭДСЭЭС ӨВЛӨСӨН БАЯР НААДМЫН ЁС

## 2. БИТҮҮН



Зураг юуг харуулж байна вэ?



### Битүүлэх ёсны учир

Битүүний өдөр монголчууд гэр орон, хашаа хороогоо цэмцийтэл сайхан цэвэрлэдэг. Энэ нь шинэ оноо хир буртаг, өвчин зовлонгүй, өнгө жавхаатай угтахыг бэлгэдэж буй хэрэг юм.

Сар бүрийн эцсийн өдрийг битүүн гэдэг. Учир нь энэ үед сар харагдахгүй болдог. Өвлийн адаг сарын эцсийн үдэш бол битүүний орой юм.



Битүүний орой тэнгэрт сар үл үзэгдэн битүү харанхуй болох үед битүүлнэ. Энэ бол хуучин оноо үдэх ёслол. Битүүлэхдээ эхлээд хоёр оны заагийг гаргах буюу битүү гаргах ёсыг үйлдэнэ. Ингэхдээ өнгөрөн одож буй жил нь өлзий хишгээ хайрласныг ярилцаж, ирж буй шинэ оноо сайн сайхан байхыг ерөөнө. Нутаг нутагт өөр өөр ёстой боловч ихэнхдээ хонины битүү толгой чанаж, эрүү, толгойг зааж салгана. Чанасан шаант чөмгийг гэрийн эзэн сайхан мөлжөөд “Битүү гаргах уу?” хэмээн гэрийн доторх бүх хүнээс асуудаг. Ингэхэд гэрийнхэн “Гаргая” гэгцгээнэ. Гэрийн эзэн шаант чөмгийг нэг удаагийн цохилтоор ташиж хагалах учиртай. Шаант чөмөг хугарахад “Битүү гарлаа” гэгцгээнэ. Дараа нь насны эрэмбээр “Тавтай битүүлж байна уу?” хэмээн мэндэлцгээдэг. Ингээд битүүний дайллага цайллага эхэлж, хүүхэд багачууд шагайн наадгай тоглож, хөөр хөгжөөнтэй болно.



Битүүн гэж ямар өдрийг хэлэх вэ?

Битүүний өдөр

А хуучин оны сүүлчийн өдөр

Б шинэ оны эхний өдөр





Битүү гаргахад ямар ёс үйлддэг вэ? Битүүний орой хийх үйлдэл, хэлэх үгийг ялгаж бичээрэй.

Битүүн болон цагаан сараар сүүтэй цай, ааруул, өрөм, бяслаг, айраг, хайлмаг зэрэг цагаан идээ, ундаа бэлддэг. Энэ нь цагаанаар бэлгэдэж, сайн сайхныг хүсэж буй хэрэг. Мөн шүүс хэмээх чанасан махыг тавагт ёс журмаар нь байрлуулж тавина.

Битүүний оройн гол хоол нь битүү хоол буюу бууз, банш байдаг. Битүүний орой хүн бүрийн ходоод гэдэс дүүрэн байх буюу өлссөн хүн байх учиргүй. Тиймээс “Битүүний орой битүүртлээ иднэ” гэдэг шог хэлц гарчээ. Гэхдээ битүүний орой их идэх нь чухал бус. Харин бэлгэтэй сайхан үг хэлэлцэж, баяр хөөр, инээд баясал дүүрэн байхыг чухалчилдаг.



Битүүн болон цагаан сарын идээ, ундааг юугаар бэлддэг вэ? Яагаад?



- Чи битүүний өдөр гэрийнхэндээ хэрхэн тусалдаг вэ?
- Танай гэрийнхэн хэрхэн битүүлдэг вэ?



Энэ хичээлээс чи юуг нэмж мэдсэн бэ?

### 3. ЕРӨӨЛӨӨР БОЛОГ



Цагаан гэдэг үгтэй хоршоо үг олж, нэмж бичээрэй. Жишээлбэл, цагаан сэтгэл.



- Ямар зүйлсийг цагаантай зүйрлэж байна вэ? Сайн сайхан уу, эсвэл муу юу?
- Та нар цагаан өнгийн ямар ямар бэлгэдлийг мэдэх вэ?





Цагаан сар бол Ази тивийн олон улс орон, Монгол түмний шинэ оны баяр юм. Энэхүү баярыг “Цагаан сар” гэж нэрлэсэн нь утга учиртай. Учир нь цагаан өнгө бол монголчуудын хамгийн ихээр эрхэмлэн дээдэлдэг, өлзий ерөөлтэй, баяр жаргалын өнгө. Сайн сайхан бүхнийг цагаантай зүйрлэн цагаан сэтгэл, цагаан буян, цагаан үйл хэмээдэг. Тиймээс цагаан сарын хамгийн хүндтэй нь цагаан идээ, түүгээр хийсэн хоол зоог байдаг. Цагаан идээгээр хийсэн зоогийг цагаалга гэнэ. Монгол айл бүр цагаан сарын тавгийн идээгээ цагаан идээгээр засаж, цагаалга бэлддэг. Харин ирсэн зочин бүр цагаалга, цагаан идээнээс заавал амсаж гарна. Энэ нь тэр зочны ажил, үйл хэрэг шинэ онд саад тотгоргүй, цагаан мөрөөр яваг хэмээсэн ерөөл юм.

Эрт үед монголчууд цагаан сараар хөгшин, залуу ялгаагүй бүгд цагаан дээл, хувцас өмсдөг байжээ.



- Монголчууд шинэ оны баяраа яагаад “Цагаан сар” гэж нэрлэсэн бэ?
- Цагаан сарын хамгийн хүндтэй зоог юу вэ?
- Цагаан сараар айлд зочлохдоо юунаас заавал амсах ёстой вэ?

## 4. ЦАГААН САРЫН МЭНДЧИЛГЭЭ



Цагаан сараар та нар хэрхэн золгодог вэ?



Хүний насны онцлогтой тохируулан хэрхэн мэндлэх вэ?

- |              |   |
|--------------|---|
| Ахмад хүн ●  | ● Та, амархан сайн байна уу?              |
| Дүүмэд хүн ● | ● Амар байна уу?                          |
| Олон хүн ●   | ● Сар шинэдээ сайхан шинэлцгээж байна уу? |




Хүний эрхэлж буй ажил үйлтэй нь тохируулан хэлэх мэндийг үгийг олоорой.

- Сурагч хүүхэд ● ● Амар сайн уу? Ажил үйлс амжилт бүтээлээр арвин уу?
- Үеийн хүмүүс хоорондоо ● ● Амар байна уу? Мал сүрэг тарган тавтай юу?
- Малчин хүнтэй ● ● Амар сайн уу? Эрдэм ном их сурав уу?
- Багш хүнтэй ● ● Амар байна уу? Сурсан шавийн тань эрдэм их, сургасан таны үйлс бүтэмжтэй юу?



Дараах хүмүүст хэлж болох мэндийн үгийг зохиож бичээрэй.





Цагаан сараар мэнд мэдэж золгоод, насны эрэмбээр суудалд суусны дараа хөөрөг зөрүүлдэг. Хөөрөг зөрүүлэхэд хэлдэг дараах үгсийг цээжлээд, цагаан сараар хэлж хэвшээрэй.



Даага далантай  
Бяруу булчинтай  
Төлөг сүүлтэй  
Тором бөхтэй  
Борлон хэрсэнтэй  
Өнөд тарган  
Өег цатгалан сайхан  
шинэлж байна уу?

Буурал жил морилж  
Буянтай жил ирж  
Өвгөн жил морилж  
Өлзийтэй жил ирсэн  
Баясгалантай шинэлсний  
Баярыг айлтгая.



Хөөрөг зөрүүлэхэд хэлдэг дээрх үгсийн утгыг тайлбарлаж бичээрэй. Дараах үгс ямар утгатайг тайлбар толиос харж, ахмад хүнээс асуугаарай.

Далан	Өнөд	Төлөг
Тором	Борлон	Буурал жил
Өег	Хэрсэн	Өлзийтэй жил



Цагаан сараар зочилсон айлаас гарахдаа үлдсэн хүмүүст юу гэж хэлэх вэ?

- Тавтай сайхан шинэлээрэй.
- Сайхан амраарай.
- Баяртай.
- Сар шинэдээ сайхан шинэлээрэй.

## 5. ЦАГААН САРЫН ЦЭЭР



Хүүхдүүд та нар цагаан сараар юу хэлж, хийж болохгүй, цээрлэдэг талаар мэдэх үү?

**Цээр:** хийж болохгүй, хийхгүй байхыг хичээх ёстой үйл



Цагаан сарын цээрийн ёсоос мэддэгээ бичээрэй.



Монголчууд цагаан сарыг хир буртаг, өр шир, өвчин эмгэг, хэрүүл маргаангүй, сайн сайхан угтахыг эрхэмлэдэг. Энэ нь шинэ ондоо ажил үйлс өөдрөг, эрүүл энх, эвтэй найртай байхыг бэлгэдэж буй хэрэг юм. Тиймээс цагаан сараар дараах зүйлсийг цээрлэдэг.

Жагсаалтыг уншаад шинээр мэдсэнээ дэвтэртээ бичээрэй.

Битүүний өдрийн цээрээс	
	Хэрүүл маргаан хийх, хүн загнах
	Мал сүргээ алдаж, хээр хонуулах
	Айлд хонох
	Өлөн зэлмэн хонох
	Хувцас хунараа гадаа хонуулах
	Бэлгэгүй, муу, ширүүн үг хэлэх
	Хийж буй ажлаа амжуулж, дуусгахгүй байх
Цагаан сарын цээрээс	
	Хир буртагтай шинэлэх
	Өртэй орох
	Хэрүүл шуугиан тарих
	Уйлж унжих, муухай аашлах
	Бэлгэгүй, муу, ширүүн үг хэлэх
	Шинийн нэгэнд айлд хонох



Яагаад тэгж цээрлэдэг вэ?



Та нар өөр ямар цээрийг мэдэх вэ? Багаараа ярилцаад бичээрэй.

## 6. ГАРЫН БЭЛЭГ



Хүүхдүүд та нар цагаан сарын баярын юунд нь дуртай вэ?

Олон бэлэг авдаг...

Амралт эхэлдэг.

Төрөл садныхаа айлуудаар зочилж дайлуулдаг.



Долоон настай Түшиг хүү цагаан сарын баярт хамгийн дуртай. Төрөл садныхнаараа зочилж, золгох бүр хамаатны буурлууд, нагац, авга нар нь өхөөрдөн, үнэрлэж золгоно. Тэгээд “Ямар том болоо вэ? Яасан сүрхий мэндэлдэг хүү вэ? Ёстой мундаг” гээд бүгд бахархана.

Бумаа эмээгийн цагаалга, Дамиран өвөөгийн бууз, Сүрэн өвөөгийн ааруул, Надмид ахын зууш хамгийн амттай. Өвөө, эмээ нь түүнд дандаа хэрэгтэй зүйлийг нь бэлэглэнэ. Зочилсон айл бүрд онцлох сайхан зүйлс бий.



Түшиг хүү яагаад цагаан сарын баярт дуртай вэ? Түүний дуртай зүйлсийг тоочиж бичээрэй.




Монголчууд цагаан сараар ирсэн зочин бүрд гарын бэлэг өгдөг. Энэ нь үнэтэй байх учиргүй. Харин ирсэн зочин нь эд зүйлээр элбэг дэлбэг байхыг бэлгэдэж, гар хоосон гаргадаггүй ёстой. Тиймээс бэлэг өгөхийг мөн цагаанаар ерөөж, “гар цайлгах” гэж нэрлэдэг. Ингэхдээ элбэг хангалуун байхыг бэлгэдэж буй учир нэг бус хоёр, эсвэл гурван зүйл гар дээр нь тавьдаг.

Өвөө, эмээгийн үед хүүхдүүдийн гарыг ихэвчлэн нимгэн дэвтэр, харандаа, ааруулаар цайлгадаг байв. Ээж, аавын үед чихэр, алим зэргийг бэлэглэдэг байв. Харин одоо бидний авдаг бэлэг өөр, илүү гоё болжээ.



Өвөө эмээ, аав ээж чинь хүүхэд байхдаа цагаан сараар ямар бэлэг авдаг байсныг ярилцаарай.



20 жилийн дараа цагаан сараар хүүхдүүдийн гарыг юугаар цайлгадаг болох бол?



Цагаан сарын бэлэг гоё сайхан, их үнэтэй байх нь чухал биш. Хамгийн гол нь ёс бэлгэдэлтэй, чин сэтгэлийнх байх учиртай.

## ТАВАН ХОШУУ МАЛАА ТАВАН ХУРУУ ШИГЭЭ МЭДЬЕ

### 7. ТАВАН ХОШУУ МАЛЫН НАС



Байгалийн бэлчээрт бэлчиж, төрөл бүрийн ашиг шим өгдөг, гэршүүлсэн адгуусыг мал гэнэ. Нүүдэлчин монголчуудын хөрөнгө нь таван хошуу мал байдаг. Тиймээс мал хөрөнгө хэмээн хоршин өгүүлдэг. Монголчууд малынхаа ашиг шимээр бүх хэрэгцээгээ хангадаг.

#### 1. Адуу

Таван хошуу малын дотроос монголчуудын хамгийн эрхэмлэдэг нь адуу юм. Адуу бол маш сонор соргог, эзэндээ ээлтэй бод мал. Адууны өвөг нь тахь бөгөөд одоо зөвхөн Монголд зэрлэг онгоноор бэлчиж байна. Монгол адууны тэсвэр, чадал нь гайхамшигтай. Нэгэн цагт монгол морины туурай дэлхийн хуурай газрын ихэнхэд хүрч байсан. Адууны ашиг шим олон зүйл бөгөөд гүүний айраг ихэд алдартай. Эрийн гурван наадмын нэг нь хурдан морины уралдаан юм.



Адууны нас	Нэршил
1 нас	Эр унага, охин унага
2 нас	Даага, сарваа-хоёр нас хүрэх дөхөж буй унага
3 нас	Шүдлэн
	3-4 насны агтлаагүй эрийг үрээ, эмийг нь байдас гэнэ.
4 нас	Хязаалан
5 нас	Соёолон
6-аас дээш нас	Их нас (сунгах соёолон, гүйцмэл)

- ▶ агтлах = засах, хөнгөлөх
- ▶ агт=морь

- ▶ Хавчиг соёолон: 6 нас хүрсэн ч соёо нь ургаж гүйцээгүй адуу. Тиймээс соёолон, их нас хоёрын дунд хавчигдсан гэж үзэн хавчиг соёолон гэж нэрлэжээ.



Адуу ямар ашиг тустай вэ?

Ачилга

Уналга

Айраг

Арьс шир

Гүүний сүү: Саам




## 2.Үхэр

Үхэр нь дөлгөөн тайван, удаан явдалтай бод мал.

Үхрийн нас	Нэршил	
	Эр	Эм
1 нас	Тугал (сарлагийн нэг настай төлийг торой гэнэ)	
2 нас	Бяруу	
3 нас	(Шүдлэн) гунан үхэр	(Шүдлэн) гунжин үнээ
4 нас	Хязаалан үхэр: Дөнө (дөнөн)	Дөнж
5 нас	Соёолон үхэр: Шар-хөнгөлсөн эр үхэр	Үнээ


Үнээний сүүгээр төрөл бүрийн цагаан идээ боловсруулна. Үнээний сүү тослог ихтэй тул хөөрүүлж загсаагаад өрөм, зөөхий гаргаж авна. Мөн хөөрүүлсэн сүүгээр цай сүүлж уухаас гадна тараг бүрж, айраг исгэж, бяслаг шахаж, ааруул, аарц хийдэг. Үхрийн арьс шириг үйлдвэрт боловсруулан цүнх, гутал, гутлын ул зэргийг хийнэ. Харин гар аргаар боловсруулан малын тоног хэрэгсэл, сур, хөхүүр зэргийг хийдэг.




## 3.Тэмээ

Тэмээ бол говь цөл, цөлөрхөг бүсийн байгальд зохицсон, арвин ашиг шим өгдөг бод мал. Хоёр бөхтэй тэмээ Төв Ази, Монгол нутагт тархсан. Тэмээний өвөг нь зэрлэг тэмээ буюу хавтгай. Хавтгай одоо ч Монголд зэрлэг онгоноороо бэлчиж байна.

Тэмээний нас	Нэршил	
	Эр	Эм
Нэг нас хүртэл	ботго	
1-2 нас	Тором	
3 нас	Гуна	Гунж, гунжин
4 нас	Дөнө, тайлаг (засаагүй эр тэмээ)	Дөнжин тэмээ
5 нас	Ат (зассан эр тэмээ)	Ингэ



Ингэний сүүг хөөрүүлэн загсааж өрөм, зөөхий гарган авдаг. Мөн ингэний сүүг исгэн айраг буюу хоормог, буцалган өтгөрүүлж аарц, ааруул зэрэг цагаан идээ боловсруулна. Тэмээний ноосоор дулаан цамц, хувцас хийнэ. Тэмээний ширээр гутлын зулаг, түрий, ул зэргийг хийхэд тохиромжтой. Тэмээг 2-3 настайд нь унаж сургадаг бол 4-5 настайд нь ачлага, хөллөгөөнд сургана. Уналга, ачлагад сургасны дараа тэргэнд хөллөнө. Тэмээн хөсгөөр голдуу жин тээдэг.



#### 4. Хонь

Хонь бол номхон зантай бог мал. Хонь, ямааны сүүгээр өрөм, зөөхий, тараг, бяслаг, айраг, аарц, ааруул, эзгий хийх зэрэг цагаан идээ боловсруулж хүнсэндээ хэрэглэнэ. Хонины ноосоор дулаан цамц, хувцас хийнэ. Ноосыг сайтар савж бэлтгээд эсгий болон бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Хонь, ямааны арьсыг нэхий гэдэг. Нэхийг элдэж боловсруулаад дээл доторлоно. Харин ямааны арьсаар дах, дэгтий хийж, өвлийн улиралд хонь малдаа явах, аян жин тээхдээ өмсөж хэрэглэнэ. Монголчууд хонины махыг ихэд чухалчилдаг.

Хонины нас	Нэршил	
	Эр	Эм
0-1 нас	эр хурга	Охин хурга
2 нас	Эр төлөг	Охин төлөг
3 нас	Шүдлэн	Шүдлэн
4 нас	Хязаалан ирэг	Хязаалан эм хонь
5 нас	Соёолон ирэг	Соёолон эм хонь
Нас бие гүйцсэн	Ирэг (зассан эр хонь)	Нас гүйцсэн эм хонь

**Хэнз хурга**-Хавар биш, зуны сүүл, намрын эхээр гарсан хурга

### 5. Ямаа

Ямаа нь хурдан хөдөлгөөнтэй, маш соргог бог мал юм. Ямааны өвөг нь Алтайн нуруу зэрэгт зэрлэгээр идээшилж яваа янгир юм. Ямааны мах, сүү, арьсыг ашиглахаас гадна ноолуурыг самнаж авдаг. Ямааны ноолууран цамц, хувцас хөнгөн, дулаахан байдаг.




Ямааны нас	Нэршил	
	Эр	Эм
0-1 нас	Эр ишиг	Охин ишиг
2 нас	Борлон	Охин борлон
3 нас	Шүдлэн	Охин шүдлэн
4 нас	Хязаалан эр ямаа	Хязаалан эм ямаа
5 нас	Соёолон эр ямаа	Соёолон эм ямаа
6-аас дээш нас	Сэрх (зассан эр ямаа)	Нас гүйцсэн эм ямаа

## 8. ТАВАН ХОШУУ МАЛАА НАСААР НЬ ЯЛГАН НЭРЛЭЖ СУРЪЯ



1 настай төл малыг юу гэж нэрлэдэг вэ?



2 настай таван хошуу малын нэрийг дэвтэртээ ялгаж бичээрэй.

2 настай адуу	
2 настай үхэр	
2 настай тэмээ	
2 настай хонь	
2 настай ямаа	



3 настай таван хошуу малын нэрсийг жагсааж бичээд, адил нэрийг олж бичээрэй.



Адил нэрийг ижил өнгийн харандаагаар доогуур нь зурж, амандаа давтан хэлээрэй. Мөн өөрөөр нэрлэгдсэн үгсийг нэмж тогтоогоорой.

Дөрвөн настай адууг хязаалан, эр үхрийг дөнө, эмийг дөнж,  
эр тэмээг тайлаг, эмийг гунж, эр хонийг хязаалан ирэг,  
эмийг хязаалан эм хонь, мөн эр, эм ямааг хязаалан гэнэ.



Үг цээжлэх хайрцаг

- Малыг насаар нь нэрлэсэн нэрийг тогтоохын тулд хэрчмэл цаас бэлдээрэй. Тэдгээр нь ойролцоогоор хөзөрний хэмжээтэй байж болно. Хэрчмэл цаасныхаа нэг талд нь “2 настай эр үхэр” гэх мэтээр зөвхөн нас, малын төрлийг бичнэ. Ар талд нь “Бяруу” хэмээн нэрийг нь бичнэ. Ийм маягаар таван хошуу малын нэрийг нас, хүйс тус бүрээр нь бичээрэй.

Адууны нэг  
настай төл

Унага

Үхрийн нэг  
настай төл

Тугал

Тэмээний нэг  
настай төл

Ботго


Ямааны нэг  
настай төл

Ишиг

Хонины нэг  
настай төл

Хурга

- Хүүхэд бүр цээжлэх үгийн жижиг хайрцаг хийгээрэй. Хайрцаг нь цээжлэх үгс, цээжилсэн үгс хэмээх хоёр тасалгаатай байна. Малын нэрийг насаар нь ялгаж бичсэн цааснуудаа цээжлэх үгсийн тасалгаанд хийж, олон дахин гаргаж уншина.





- Нэрсийг цээжилж эхэлснээсээ хойш 2 цаг, 1 өдөр, 2 өдрийн дараа тогтоосон эсэхээ шалгаарай. Тухайн нэрийг сайн тогтоосон бол хуудас цаасаа цээжилсэн үгсийн тасалгаандаа хийнэ.
- Цээжлэх ёстой үгээ авч, олон дахин уншиж, тогтоон цээжлэхийг хичээнэ.
- Хэдэн өдрийн дараа цээжилсэн хэсгийн үгсээсээ авч өөрийгөө дахин шалгаарай. Хэрэв мартсан бол цээжлэх үгсийн тасалгаандаа буцааж хийгээд цээжлээрэй.
- Ингээд 7 хоногийн дараа хэр сайн тогтоосноо ангиараа шалгаарай.

## 9.ҮХЭР ҮҮ? САРЛАГ УУ?



Дараах гурван амьтныг та нар нэрлэж мэдэх үү?






### Сарлаг


Сарлаг бол үхрийн нэг төрөл. Гэхдээ үхрээс урт өтгөн үс, саглагар сүүлтэй, голдуу эвэргүй байдаг. Сарлаг өндөр уултай, хүйтэн сэрүүн газар амьдрахад зохицсон мал юм. Өтгөн сахлаг үстэй байдаг нь хүйтэнд даарах, халуунд нарнаас хамгаалж, цас, мөс, хайрга чулуутай газар хэвтэхэд зөөлөн дулаан дэвсгэр болдог.

Сарлагаас мах, сүү, арьс, хөөврийг нь ашиглах ба уналга, ачлагад хэрэглэнэ. Аргалыг нь түлшинд хэрэглэдэг.



### Хайнаг

Монгол үхэр, сарлаг хоёрын дундаас гарсан үхрийг хайнаг гэнэ. Хайнаг урт настай, чадал тэнхээ ихтэй, урт чацтай. Алхаа гишгээ нь уужуу, дөлгөөн зан ааштай, уналга эдэлгээнд амархан дасдаг онцлогтой. Хайнаг нь хүч тэнхээ сайтай тул ердийн хөсөг тээвэр, ачлагад өргөн хэрэглэнэ. Үнээ нь сүү сайтай.





### Ортоом

Хайнагийн үнээнээс гарсан тугалыг ортоом гэнэ. Ортоом нь амьдрах чадвар, тэсвэр хатуужлаараа сарлагаас арай сул байдаг.



Аль нь сарлаг, үхэр, хайнаг вэ?



Асуултад хариулж бичнэ үү.

- Ямар малыг хайнаг гэдэг вэ?
- Ямар малыг ортоом гэдэг вэ?



Багт хуваагдан цаа буга, цаатан хүмүүсийн талаар судалж, төсөлт хичээл хийгээрэй.

## БИ ҮҮНИЙГ МЭДДЭГ, ЧАДДАГ, ХЭРЭГЖҮҮЛДЭГ БОЛСОН



1. Дараах суралцахуйн зорилтуудыг анхааралтай уншаад, юуг мэддэг, чаддаг болсон, хэвшүүлснээ дүгнээрэй.
2. Хэвшүүлэх ёстой зүйлээ төлөвлөж хэрэгжүүлээрэй.

### I бүлэг. Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье

Монголчууд жилийн дөрвөн улирал, хүмүүсийн ажил үйлд тохируулан мэндэлдэг онцлогийг мэдэж, зөв мэндэлж сурлаа.

Хүн болж төрсөн нь ховор хувь заяа гэдгийг ойлгож, хүн болж төрсний учир цаг алдалгүй сурч, хийж бүтээх ёстойг ухаарлаа.

Хүн бусад амьтнаас зарим чадвараар дутуу ч оюун ухаан, хэл соёл, хийж бүтээх чадвартай болон сэтгэлийн хүчээр бүх амьтнаас давуу болохыг ойлголоо.

Хүн өөрийн эрхэм биеийг цаг хугацаа алдалгүй ашиглах, эрдэм номд шамдах, бие, хэл, сэтгэлээ хөгжүүлэх, бусдад туслан, энэрэн хайрлах сайн үйлсэд зориулах ёстойг ойлгосон.

Тиймээс хүн амьтан, ургамал, эх дэлхийгээ хайрлан хамгаалах үүрэгтэй.

Хэлээр үйлдэх сайн, муу үйлд ямар үйл хамаардгийг би мэдлээ.

Би сайн, муу үйлийг ялгаж, нүгэл, буян гэж юу болохыг мэддэг болсон.

Би хэлний муу үйл үйлдэхгүйг хичээж, бусдад эелдэг, зөөлөн хандахыг эрмэлздэг болсон.

Үг бол хүнийг уурлуулан гомдоож, баяр баясал бэлэглэж чадах шидтэй, хүчтэй гэдгийг би ойлгосон.

## II бүлэг. Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс

Хүн хэзээ ч ганцаараа амьдардаггүй, бусад бүх хүн надад ачтай. Тиймээс би бусдад хэлэх үг, хийх үйлдлээ сайтар боддог болсон.

Би аав, ээж, өвөө эмээ, гэр бүлийнхэн маань ямагт миний төлөө байдаг, ачтай хүмүүс гэдгийг ухаарсан.

Аав ээж, өвөө эмээ, гэр бүлийнхнээ хэрхэн хүндэлж, тэдэнтэй хэрхэн харилцах ёстойгоо мэдсэн.

Би ойр дотнын хүмүүс болон бусдад баярласнаа үг, үйлдэл, сэтгэлээрээ зөв илэрхийлдэг болсон.

Би аав ээж, багш, гэр бүлийнхэн, төрөл садан, нутаг усныхан, найз нөхдийн тус дэмд хэрхэн талархах ёстойг ухаарсан.

Би бусдыг ялгаварлалгүй тэгш хандаж, талархал илэрхийлдэг болсон.

## III бүлэг. Уламжлалт аж төрөх ёс, зан үйл

Би таван хошуу малыг насаар нь ялган нэрлэж чадна.

Би битүүлэх ёсны учир утга, хэрхэн битүүлэх ёстойг мэднэ.

Цагаан сар, битүүний өдөр юуг бэлгэдэх, юуг цээрлэхийг мэдэж авлаа.

Цагаан сарын хамгийн хүндтэй идээ нь яагаад цагаан байдгийн учрыг би мэдсэн.

Би цагаан сарын баяраар гар цайлгадаг ёсны учир, бэлгэдлийг мэднэ.

Би сарлаг, хайнаг, ортоом үхрийг хооронд нь ялгаж чадна. Бас тэдний онцлогийг мэднэ.